

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны бүтээл нь 3 бүлэгт үр дүнгийн тайлан, хэлцэмж, дүгнэлт зөвлөмж болон 75 хүснэгт, 61 дүрслэл, 3 хавсралтаас бүрдэж байна.

Судалгаанд баримтын болон чанарын судалгааны аргыг ашиглан, 2009-2012 оны эрүүл мэндийн статистик үзүүлэлтэд тулгуурлан, эрүүл мэндийн ажиллах хүчний нас хүйсний бүтэц, байршил, хангамжийн динамикийг байгууллагаар болон мэргэжлээр ангилан, улс, аймаг, Улаанбаатар хотоор тус бүрээр авч үзлээ.

Энэхүү судалгаагаар Монгол улсын дундаж хүн амын болон эрүүл мэндийн ажиллах хүчний харьцааг харьцуулан гаргаж, ялангуяа аймаг, дүүрэг тус бүрээр хүн амын өсөлт, бууралтыг харьцуулан авч үзсэнээр чухал юм.

Мөн олон улсын болон Монгол улсын 10000 хүнд ногдох их эмч, сувилагч эх баригч, шүдний эмч, эм зүйч мэргэжлийг улс, аймаг, Улаанбаатар хотоор харьцуулан дүгнэлт хийлээ.

Судалгаанд ЭМЯ-ны харьяа эрүүл мэндийн 14 байгууллагын хүний нөөцийн чадавхи, төрөлжсөн мэргэжлийн хангамж, ажлын туршлага, тусламж, үйлчилгээ, шинэ дэвшилтэт технологитой уялдан суралцуулах болон орон тооны хэрэгцээг чанарын судалгааны аргаар судлан тоймлон дүгнэлээ.

Судалгааны үр дүнгээс харахад эрүүл мэндийн салбарт дийлэнх нь эмэгтэйчүүд ажиллаж, насны хувьд жил ирэх тутам залуужих хандлага ажиглагдаж байна.

Хүн амын 54.1%, эрүүл мэндийн нийт ажиллах хүчний 48.6%, их эмчийн 37.7%, сувилагчийн 49.5% нь хөдөө аймагт байршиж байна. Улаанбаатар хотод хүн амын 45.9%, ажиллах хүчний 51.4%, их эмчийн 62.3%, сувилагчийн 50.5% нь байршиж байна.

Эрүүл мэндийн байгууллагын тооны өсөлтөд рашаан сувилал, хувийн үүдэн эмнэлэг, эмийн сангийн өсөлт голлох байр суурь эзэлж байна. Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний өсөлт жил тутам нэмэгдсэн ба өсөлтөд хүн амын өсөлт, бууралт, шилжилт хөдөлгөөн харилцан хамаарал багатай, өөрөөр хэлбэл аймгуудын хүн амын тоо буурсаар байхад, ажиллах хүчний тоо нэмэгдсээр байна.

2012 оны эрүүл мэндийн үзүүлэлтээр Монгол улсад 10000 хүнд **30.3** их эмч ногдож байгаа нь хөгжиж байгаа орнуудаас 3 дахин, хөгжингүй орнуудаас 1.4 дахин, өндөр хөгжилтэй орнуудаас 0.9 дахин, дэлхийн болон олон улсын дунджаас 2.1 дахин өндөр байна. Мөн аймагт **21.1**, Улаанбаатар хотод **41.1** их эмч ногдож байгаа нь дэлхийн болон олон улсын дунджаас өндөр байна.

Монгол улсад 10000 хүнд ногдох сувилагч эх баригч дэлхийн болон олон улсын дунджаас 1.1 дахин, эм зүйч 1.6 өндөр байгаа бол шүдний эмч 0.8 дахин, нийгмийн эрүүл мэндийн ажилтан 1.5 дахин бага байна.

Лавлагаа төвүүдэд дэвшилтэт технологитой уялдан мянга гаруй хүнийг БНСУ, Тайвань, АНУ, Франц, Япон, ХБНГУ, ОХУ, Сингапур, Энэтхэг, Австрали, Казакстан зэрэг улс орнуудад болон өөрийн орондоо төрөлжсөн мэргэжлийн онцлогоос хамааран 3-6 сарын хугацаатай суралцан мэргэжил дээшлүүлэхийг чухалчилж байна. Шинээр мэргэшүүлэх мэргэжлийн дийлэнх нь сувилагч мэргэжил байна.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:

АУБ	АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛ
АӨСҮТ	АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
ГССҮТ	ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
ГҮТ	ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ДЭМБ	ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА
ЗӨСҮТ	ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
МДИ	МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ ИНСТИТУТ
НЭМ	НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД
СЭМҮТ	СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
УНТЭ	УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ
УХТЭ	УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ
УГТЭ	УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ
ХСҮТ	ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
ХӨСҮТ	ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
ХТС	ХҮҮХДИЙН ТӨВ СУВИЛАЛ
ЦССҮТ	ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
ЭМЯ	ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭМШУИС	ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ
ЭХЭМҮТ	ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ЭСҮТ	ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

ГАРЧИГ

НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, СУДЛАГДСАН БАЙДАЛ

ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, МАТЕРИАЛ

ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

БҮЛЭГ 3.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙТ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХҮЙС, НАСНЫ БҮТЭЦ,

БАЙРШИЛ, ХАНГАМЖИЙН ДИНАМИК

3.1.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙТ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХҮЙС, НАСНЫ БҮТЦИЙН ДИНАМИК

3.1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙТ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ БАЙРШИЛ, ХАНГАМЖИЙН ДИНАМИК-БАЙГУУЛЛАГААР

3.1.3. ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙТ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ БАЙРШИЛ, ХАНГАМЖИЙН ДИНАМИК-МЭРГЭЖЛЭЭР

3.1.4. ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙТ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ

БҮЛЭГ 3.2. ХҮН АМ-ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХАРЬЦАА

3.2.1. ОЛОН УЛСЫН БОЛОН МОНГОЛ УЛСЫН 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, МОНГОЛ УЛСЫН НИЙТ ХҮН АМ - ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХАРЬЦАА

3.2.2. АЙМАГ, ХОТЫН ХҮН АМ -ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХАРЬЦАА

БҮЛЭГ 3.3. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХАРЬЯА ЛАВЛАГАА ТӨВҮҮДИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИ БА ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

3.3.1. УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

3.3.2. УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ

3.3.3. УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ

3.3.4. ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

3.3.5. ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

3.3.6. ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

3.3.7. ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

3.3.8. АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

3.3.9. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

3.3.10. ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

3.3.11. ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

3.3.12. ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

3.3.13. ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

3.3.14. ХҮҮХДИЙН ТӨВ СУВИЛАЛ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ НАСНЫ БҮЛГИЙН ДИНАМИК

ХҮСНЭГТ 2. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ БАЙРШИЛ- БАЙГУУЛЛАГААР

ХҮСНЭГТ 3. ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙТ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХАНГАМЖ -МЭРГЭЖЛЭЭР

ХҮСНЭГТ 4. АНХДАГЧ ШАТЛАЛЫН АЖИЛЛАХ ХҮЧИН-МЭРГЭЖЛЭЭР

ХҮСНЭГТ 5. ХОЁРДОГЧ ШАТЛАЛЫН АЖИЛЛАХ ХҮЧИН-МЭРГЭЖЛЭЭР

ХҮСНЭГТ 6. ГУРАВДАГЧ ШАТЛАЛЫН АЖИЛЛАХ ХҮЧИН-МЭРГЭЖЛЭЭР

ХҮСНЭГТ 7. ИХ ЭМЧ ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР (2012 ОН)

ХҮСНЭГТ 8. ИХ ЭМЧ ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР –ШАТЛАЛААР (2012 ОН)

ХҮСНЭГТ 9. ЭРДМИЙН БОЛОН БОЛОВСРОЛЫН ЗЭРЭГТЭЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧИН

ХҮСНЭГТ 10. МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧИН

ХҮСНЭГТ 11. УДИРДАХ АЖИЛТАН, ИХ ЭМЧ, ТУСГАЙ МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ХАМГААЛАЛТ

ХҮСНЭГТ 12. ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН 10000 ХҮНД НОГДОХ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

ХҮСНЭГТ 13. ДЭМБ-ЫН БҮС НУТГИЙН БОЛОН ОЛОН УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН 10000 ХҮНД НОГДОХ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

ХҮСНЭГТ 14. АЙМГУУДЫН ХҮН АМ, ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ТОО, ӨСӨЛТ БУУРАЛТЫН ХУВЬ

ХҮСНЭГТ 15. АЙМГУУДЫН АЖИЛЛАХ ХҮЧИН-МЭРГЭЖЛЭЭР

ХҮСНЭГТ 16. АРХАНГАЙ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

ХҮСНЭГТ 17. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

ХҮСНЭГТ 18. БУЛГАН АЙМГИЙН ХҮН АМ-ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

ХҮСНЭГТ 19. ОРХОН АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

ХҮСНЭГТ 20. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

ХҮСНЭГТ 21. ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

ХҮСНЭГТ 22. СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

ХҮСНЭГТ 23. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

ХҮСНЭГТ 24. ТӨВ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

ХҮСНЭГТ 25. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

ХҮСНЭГТ 26. ДОРНОГОВЬ ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

ХҮСНЭГТ 27. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

ХҮСНЭГТ 28. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

ХҮСНЭГТ 29. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ

	ДИНАМИК
ХҮСНЭГТ 30.	ЗАВХАН АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК
ХҮСНЭГТ 31.	УВС АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК
ХҮСНЭГТ 32.	ХОВД АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК
ХҮСНЭГТ 33.	ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК
ХҮСНЭГТ 34.	ДОРНОД АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК
ХҮСНЭГТ 35.	СҮХБААТАР АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК
ХҮСНЭГТ 36.	ХЭНТИЙ ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК
ХҮСНЭГТ 37.	УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК
ХҮСНЭГТ 38.	УНТЭ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН
ХҮСНЭГТ 39.	УНТЭ-ИЙН ИХ ЭМЧИЙН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ
ХҮСНЭГТ 40.	УНТЭ-ИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ХЭРЭГЦЭЭ
ХҮСНЭГТ 41.	УХТЭ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН
ХҮСНЭГТ 42.	УХТЭ-ИЙН ИХ ЭМЧИЙН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ
ХҮСНЭГТ 43.	УХТЭ-ИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ХЭРЭГЦЭЭ
ХҮСНЭГТ 44.	УГТЭ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН
ХҮСНЭГТ 45.	УГТЭ-ИЙН ИХ ЭМЧИЙН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ
ХҮСНЭГТ 46.	УГТЭ-ИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ХЭРЭГЦЭЭ
ХҮСНЭГТ 47.	УГТЭ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН
ХҮСНЭГТ 48.	ГССҮТ-ИЙН ИХ ЭМЧИЙН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ
ХҮСНЭГТ 49.	ГССҮТ-ИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ХЭРЭГЦЭЭ
ХҮСНЭГТ 50.	ХСҮТ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН
ХҮСНЭГТ 51.	ХСҮТ-ИЙН ИХ ЭМЧИЙН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ
ХҮСНЭГТ 52.	ХСҮТ-ИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ХЭРЭГЦЭЭ
ХҮСНЭГТ 53.	ЭХЭМҮТ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН
ХҮСНЭГТ 54.	ЭХЭМҮТ-ИЙН ИХ ЭМЧИЙН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ
ХҮСНЭГТ 55.	ЭХЭМҮТ-ИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ХЭРЭГЦЭЭ
ХҮСНЭГТ 56.	ХӨСҮТ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН
ХҮСНЭГТ 57.	ХӨСҮТ-ИЙН ИХ ЭМЧИЙН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ
ХҮСНЭГТ 58.	ХӨСҮТ-ИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ХЭРЭГЦЭЭ
ХҮСНЭГТ 59.	АӨСҮТ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН
ХҮСНЭГТ 60.	АӨСҮТ-ИЙН ИХ ЭМЧИЙН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ
ХҮСНЭГТ 61.	АӨСҮТ-ИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ХЭРЭГЦЭЭ
ХҮСНЭГТ 62.	СЭМҮТ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН
ХҮСНЭГТ 63.	СЭМҮТ-ИЙН ИХ ЭМЧИЙН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ
ХҮСНЭГТ 64.	СЭМҮТ-ИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ХЭРЭГЦЭЭ
ХҮСНЭГТ 65.	ГҮТ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН
ХҮСНЭГТ 66.	ГҮТ-ИЙН ИХ ЭМЧИЙН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ
ХҮСНЭГТ 67.	ЭСҮТ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН
ХҮСНЭГТ 68.	ЭСҮТ-ИЙН ИХ ЭМЧИЙН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ
ХҮСНЭГТ 69.	ЗӨСҮТ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН
ХҮСНЭГТ 70.	ЗӨСҮТ-ИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ХЭРЭГЦЭЭ
ХҮСНЭГТ 71.	ЦССҮТ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН
ХҮСНЭГТ 72.	ЦССҮТ-ИЙН ЭМЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ
ХҮСНЭГТ 73.	ЦССҮТ-ИЙН -ИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ХЭРЭГЦЭЭ
ХҮСНЭГТ 74.	ХТС-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН
ХҮСНЭГТ 75.	ХТС-ИЙН ЭМЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

ДҮРСЛЭЛ 1.	ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХҮЙСНИЙ ХАРЬЦАА
ДҮРСЛЭЛ 2.	ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙТ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ НАСНЫ БҮТЦИЙН ДИНАМИК
ДҮРСЛЭЛ 3.	ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН НАСНЫ БҮТЦИЙН ДИНАМИК
ДҮРСЛЭЛ 4.	ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧИН- БАЙГУУЛЛАГЫН ТОО
ДҮРСЛЭЛ 5.	АНХДАГЧ ШАТЛАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК
ДҮРСЛЭЛ 6.	ХОЁРДОГЧ ШАТЛАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК
ДҮРСЛЭЛ 7.	ГУРАВДАГЧ ШАТЛАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК
ДҮРСЛЭЛ 8.	ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙТ АЖИЛЛАХ ХҮЧИН -МЭРГЭЖЛЭЭР
ДҮРСЛЭЛ 9.	ИХ ЭМЧИЙН БАЙРШИЛ, ХАНГАМЖИЙН ДИНАМИК
ДҮРСЛЭЛ 10.	УДИРДАХ АЖИЛТНЫ БОЛОВСРОЛЫН БОЛОН МЭРГЭЖЛИЙН ЗЭРГИЙН ДИНАМИК
ДҮРСЛЭЛ 11.	НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН ОРНУУДЫН 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ ¹
ДҮРСЛЭЛ 12.	МОНГОЛ УЛСЫН ДУНДАЖ ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧИН
ДҮРСЛЭЛ 13.	АЙМГУУДЫН ДУНДАЖ ХҮН АМ -ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧИН

¹ WHO, World health statistics 2013 /128-р хуудас/

- ДҮРСЛЭЛ 14. АЙМГУУДЫН ХҮН АМ -ЭРҮҮЛ МЭНДИЙН 10000 ХҮН АМД НОГДОХ АЖИЛЛАХ ХҮЧИН
- ДҮРСЛЭЛ 15. АРХАНГАЙ АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 16. АРХАНГАЙ АЙМГИЙН ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 17. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 18. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 19. БУЛГАН АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 20. БУЛГАН АЙМГИЙН ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 21. ОРХОН АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 22. ОРХОН АЙМГИЙН ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 23. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 24. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 25. ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 26. ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 27. СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 28. СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 29. ДАРХАН АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 30. ДАРХАН ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 31. ТӨВ АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 32. ТӨВ ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 33. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 34. ГОВЬСҮМБЭР ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 35. ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 36. ДОРНОГОВЬ ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 37. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 38. ДУНДГОВЬ ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 39. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 40. ӨМНӨГОВЬ ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 41. БАЯНӨЛГИЙ АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 42. БАЯНӨЛГИЙ ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 43. ЗАВХАН АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 44. ЗАВХАН ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 45. УВС АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 46. УВС ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 47. ХОВД АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 48. ХОВД ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 49. ХОВД АЙМГИЙН ХҮН АМ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 50. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 51. ГОВЬ-АЛТАЙ ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 52. ДОРНОД АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 53. ДОРНОД ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 54. СҮХБААТАР АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 55. СҮХБААТАР ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 56. СҮХБААТАР АЙМГИЙН ХҮН АМ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧИН
- ДҮРСЛЭЛ 57. ХЭНТИЙ АЙМГИЙН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 58. ХЭНТИЙ ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 59. УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМ БА 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД
- ДҮРСЛЭЛ 60. УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМЫН БОЛОН АЖИЛЧДЫН ӨСӨЛТИЙН ХУВЬ
- ДҮРСЛЭЛ 61. УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧИН

ХАВСРАЛТ 1. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ БАЙРШИЛ, ХАНГАМЖ-АЙМГААР

ХАВСРАЛТ 2. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ БАЙРШИЛ, ХАНГАМЖ- ДҮҮРГЭЭР

ХАВСРАЛТ 3. ЭМЯ-НЫ ХАРЬЯА ТӨВ ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВҮҮДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ БАЙРШИЛ ХАНГАМЖ

НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, СУДЛАГДСАН БАЙДАЛ

Үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээг үзүүлэх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний хөгжил, оновчтой байршил, хангамж чухал юм.

2012 оны байдлаар 43626 эрүүл мэндийн ажиллах хүчний 42103 хүн нь эрүүл мэндийн салбартаа ажиллаж байна. Үүнээс 8597 их эмч, 9916 сувилагч, нийт 16871 эмнэлгийн тусгай мэргэжилтэн байна.

Эмч, сувилагчийн харьцаа өндөр хөгжилтэй орнуудад 1:2.7 байдаг бол манай орны хувьд 1990 онд 1:1, 1994-2004 онд 1:1.2, 2008 онд 1:1.2, 2012 онд 1.9 байгаа ба олон улсын түвшинд хүргэхэд сувилагчийн тоог 15000 орчимд нэмэх шаардлага харагдаж байна.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг өрх, сумын эрүүл мэндийн төвд 1444 их эмч ажиллаж байгаа нь их эмчийн 16.7% эзэлж байгаа бол НЭМ-ийн мэргэжилтэн 536 хүний 9.5% нь анхдагч шатлалд ажиллаж байгаа нь харьцангуй бага тоо юм.

2012 оны байдлаар улсын дунджаар 10.000 хүн амд их эмч 30.3 ногдож байгаа нь дэлхийн дунджаас² (14.0) 2.2 дахин өндөр байна. Түүнчлэн аймгийн 10000 хүнд дунджаар 21.1, Улаанбаатар хотын 10000 хүнд 41.1 их эмч ногдож байгаа нь эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн байршуулалт жигд бус байгааг харуулж байна.

Эрүүл мэндийн салбарын хүний нөөцтэй холбоотой:

- М.Шагдарсүрэн, Ш.Оюунбилэг нарын Эрүүл мэндийн боловсон хүчний хөгжил, төлөвлөлт.,
- С.Дуламсүрэн, И.Бат-Эрдэнэ нарын “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн дунд хугацааны төлөв байдал 2005-2015”.,
- С.Дуламсүрэн, Т.Болормаа, Б.Булганчимэг бусад “Эрүүл мэндийн мэргэжлийн ажиллах хүчний хэрэгцээ, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн үнэлгээ”.,
- Ш.Оюунбилэг, Л.Ширнэн нарын “Эмнэлгийн мэргэжилтний ажил үүргийн шинжилгээ”, “Төгсөлтийн дараах мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтын хэрэгцээ”.,
- Б.Ганбатын “Эмч нарын мэргэжлийн тасралтгүй сургалтын өнөөгийн байдал, хэтийн төлөвийн асуудалд”.,
- Л.Оюунтогос, Э.Эрдэнэчимэг бусад “Эмч, эмнэлгийн мэргэжилтний цалингийн одоогийн тогтолцоо, хөдөлмөрийн норм болон үнэмлэмжид үнэлгээ өгөх судалгаа”.,
- Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ажлын ачаалал (ЭМШУИС) зэрэг цөөнгүй тооны эрдэм шинжилгээ судалгааны бүтээлүүд байна.

Манай улсад эрүүл мэндийн салбарын шинэчлэл, дэвшилтэт технологийн нэвтрэлт, хүн амын өвчлөлтэй уялдан шинэ мэргэшлийг бий болгох эрэлт хэрэгцээ бий болж байна.

Тухайлбал: ахуй засалч, хэл ярианы гажиг засалч, хөдөлгөөн засалч болон эмнэлгийн өндөр технологийн тоног төхөөрөмжийн инженер, техникийн ажилтан зэрэг мэргэжлийг дурдаж болно. Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг төгөлдөржүүлэх, хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх, эрүүл мэндийг хамгаалах, дэмжих технологийг хөгжүүлэхэд эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний нөөц, байршил, хангамж, мэргэшсэн боловсон хүчний чадавхи чухал юм.

Иймд хүний нөөцийн байршил, хангамжийн 4 жилийн (2009-2012) динамик болон хүний нөөцийн чадавхи, дэвшилтэт технологитой уялдуулан төрөлжсөн мэргэжлийн сургалтын хэрэгцээ, шаардлагыг судлах нь энэхүү ажлын үндэслэл болж байна.

Зорилго: Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн байршил, хангамж, чадавхи, хэрэгцээг судлах

Зорилт :

1. Эрүүл мэндийн ажиллах хүчний бүтэц, байршил, хангамжийн 4 жилийн динамикийг гаргах
2. Монгол улсын хүн амын тоо, эрүүл мэндийн ажиллах хүчний харьцааг судлах
3. Төрөлжсөн мэргэжлийн хүний нөөцийн чадавхи, тусламж, үйлчилгээ, сургалтын хэрэгцээг тодорхойлох

Ач холбогдол:

- Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн байршил, хангамжийн динамикт суурилан оновчтой хувиарлалт хийх, чадавхийг дээшлүүлэхэд нотолгоо болно.

² Эрүүл мэндийн статистик үзүүлэлт, 2012 он

- Сонгогдсон лавлагаа мэргэжлийн төвүүдийн хүний нөөцийн чадавхи, тусламж, үйлчилгээнд тулгуурлан, зохицуулалт хийхэд нотолгоогоор хангана.

Үр дүн:

- Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн байршил хангамж, чадавхи, хэрэгцээг тодорхойлсон үр дүнгийн тайлан бичигдсэн байна.
- Хүний нөөцийн хөгжлийг хангах, бүртгэл, мэдээллийг боловсронгуй болгоход нотолгоо болгон ашиглана.

Хугацаа: 2013.09-2014.03 сар

ХОЁР: СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, МАТЕРИАЛ:

Судалгааны арга зүй: Судалгаанд баримтын болон чанарын судалгааны аргыг ашиглана.

Баримтын судалгаагаар дараах мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийнэ:

- Эрүүл мэндийн нийт байгууллагуудын хүний нөөцийн байршил, хангамжийн 2009-2012 оны динамик
- Хүний нөөцийн нас, хүйсийн бүтэц, мэргэжил
- 10000 хүн амд ногдох их эмч, мэргэжлээр, 4 жилийн динамикаар
- Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн зэрэг хамгаалалт

Чанарын судалгаагаар төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдээс дараах мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийнэ:

- Чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх, стандартыг хангаж ажиллахад дутагдалтай байгаа хүний нөөц, мэргэжлээр
- Дэвшилтэт технологитой уялдан шинээр мэргэшүүлэх мэргэшлийн хэрэгцээ, шаардлага
- Хүний нөөцийн байршил, хангамж, өндөр ур чадвартай мэргэшсэн боловсон хүчин бэлтгэхэд тулгарч буй бэрхшээл, тулгамдсан асуудал

Хамрах хүрээ:

Чанарын судалгаанд зориудаар сонгосон ЭМЯ-ны харьяа эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн мэргэжилтэн, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, чанарын менежер, сургалтын албаны дарга, эрдэм шинжилгээ хариуцсан удирдлага, мэргэжилтэн, сувилахуйн албаны дарга, эмийн сангийн эрхлэгч хамрагдана.

Мэдээлэл цуглуулах хэрэгсэл: Тусгайлан боловсруулсан чанарын судалгааны асуулга болон хүснэгтэн загварыг ашиглана.

Мэдээлэл боловсруулалт: Эрүүл мэндийн статистикийн программ хангамжаас шаардлагатай тоон үзүүлэлтийг түүвэрлэн дүн шинжилгээ хийж, тусгайлан боловсруулсан асуулгын дагуу мэдээллийг нэгтгэн, дүгнэлт хийнэ.

Судалгааны ажлын хүн хүчин: Судалгааг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Тогтолцооны судалгаа, статистикийн хэлтсийн мэргэжилтнүүд удирдан явуулна.

Мэдээлэл түгээх: Судалгааны үр дүнгийн тайланг ЭМЯ-ны бодлого боловсруулагч, эрүүл мэндийн байгууллага, хэрэглэгчдэд түгээнэ.

ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН


БҮЛЭГ 3.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙТ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХҮЙС, НАСНЫ БҮТЭЦ, БАЙРШИЛ, ХАНГАМЖИЙН ДИНАМИК

3.1.1. Эрүүл мэндийн нийт ажиллах хүчний хүйс, насны бүтцийн динамик

Өнөөдрийн байдлаар Монгол улсын 1564.1 мян. кв. км нутагт 339 сум, дүүргийн 1740 баг хорооны 2.867.744 хүн амд 2925 эрүүл мэндийн байгууллагын нийт 43626 ажилтан, үүнээс 8597 их эмч, 16871 тусгай мэргэжлийн мэргэжилтэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа ба 10000 хүн амд 30.3 их эмч, 59.4 тусгай мэргэжлийн мэргэжилтэн тус тус ногдож байна.³

2009-2012 оны динамикаас харахад эрүүл мэндийн ажиллах хүчний хүйсийн бүтэц онцын өөрчлөлтгүй, 4 жилийн дунджаар эмэгтэйчүүд 82.3%-ыг эзэлж байгаа бол 7300 орчим эрэгтэйчүүд ажилладаг байна. 2012 онд хүйсийн бүтцэд бага зэрэг өөрчлөлт гарч, эрэгтэй ажиллах хүчин урд оноос 72 хүнээр буюу 0.7%-иар өссөн байна.

ДҮРСЛЭЛ 1. ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХҮЙСИЙН ХАРЬЦАА



ХҮСНЭГТ 1. ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ НАСНЫ БҮЛГИЙН ДИНАМИК

Үзүүлэлт	Он	Насны бүлгээр							ЭМБ-ын ажилтнууд
		20-оос доош	20-29	30-39	40-49	50-54	55-60	60 ба түүнээс дээш	
Ажилчдын тоо	2009	64	7165	11338	13032	4832	1821	451	38703
	2010	31	7711	11458	12948	5087	1838	535	39608
	2011	52	8657	11167	13212	5437	2008	591	41124
	2012	60	9769	11674	13518	5763	2166	676	43626
Тухайн оны нийт ажилчдад эзлэх хувь	2009	0.2%	18.5%	29.3%	33.7%	12.5%	4.7%	1.2%	100.0%
	2010	0.1%	19.5%	28.9%	32.7%	12.8%	4.6%	1.4%	100.0%
	2011	0.1%	21.1%	27.2%	32.1%	13.2%	4.9%	1.4%	100.0%
	2012	0.1%	22.4%	26.8%	31.0%	13.2%	5.0%	1.5%	100.0%


2012 оны буюу өнөөдрийн байдлаар эрүүл мэндийн нийт ажиллах хүчний (43626) 20-иос доош насныхан 0.1%, 20-29 насныхан 22.5%, 30-39 насныхан 26.8%, 40-49 насныхан 31.0%, 50-54 насныхан 13.2%, 55-60 насныхан 4.9%, 60 ба түүнээс дээш насныхан 1.5% тус тус эзэлж байна.

2009-2012 оны 4 жилийн динамикаар авч үзвэл 20-оос доош насныхан хамгийн бага хувийг (0.1%) эзэлж, ажиллах хүчний дийлэнх нь 30-49 насныхан байгаа ба жил тутам буурсан, 20-29 насныхан жил тутам нэмэгдсэн хандлага ажиглагдаж байна.


Тэтгэврийн насныхан буюу 55 ба түүнээс дээш насныхны өсөлт, бууралт 4 жилийн динамикаар ойролцоо түвшинд, дунджаар 0.2%-иар хэлбэлзэж, 2012 онд урд жилүүдээс бага зэрэг нэмэгдсэн байдал ажиглагдаж байна.

³ Эрүүл мэндийн үзүүлэлт, 2012

ДҮРСЛЭЛ 2. ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙТ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ НАСНЫ БҮТЦИЙН ДИНАМИК



ДҮРСЛЭЛ 3. ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН НАСНЫ БҮТЦИЙН ДИНАМИК



Хүний их эмчийг насны бүлгээр авч үзвэл 4 жилийн дунджаар 40-49 насныхан 27.9%, 30-39 насныхан 24.9%, 20-29 насныхан 23.0%, 50-54 насныхан 12.8%, 55-60 насныхан 7.2%, 60 ба түүнээс дээш насныхан 4.1%-ийг тус тус эзэлж байна. Хүйсээр авч үзвэл их эмчийн 79.1% нь эмэгтэйчүүд байна.

Товч дүгнэлт: 4 жилийн динамикаар хүйсийн бүтцийн өөрчлөлт бага, эрүүл мэндийн нийт ажиллах хүчний 82.3%, их эмчийн 79.1%-ийг эмэгтэйчүүд эзэлж, нийт 7300 орчим эрэгтэйчүүд ажиллаж байгаагийн 22.3% буюу 1630 нь эрэгтэй их эмч байна.

Насны бүлгээр авч үзэхэд ажиллах хүчний дийлэнхийг 30-49 насныхан эзэлж байгаа хэдий ч жил тутам буурсан, харин 20-29 насны залуу ажиллах хүчин жил тутам нэмэгдсэн хандлага ажиглагдаж байна.

3.1.2. Эрүүл мэндийн нийт ажиллах хүчний байршил, хангамжийн динамик-Байгууллагаар

Бид эрүүл мэндийн ажиллах хүчний байршил, хангамжийг тодорхойлохдоо эрүүл мэндийн нийт ажиллах хүчнийг байгууллагаар, мэргэжлээр тус тус ангилан, бодит тоон үзүүлэлтэд тулгуурлан өсөлтийг харьцуулан гаргасан болно.

ДҮРСЛЭЛ 4. ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧИН- БАЙГУУЛЛАГЫН ТОО



2009 оныг суурь он болгон, 2012 онтой харьцуулан авч үзэхэд 4 жилийн дотор байгууллагын тоо 270-аар, ажиллах хүчний тоо 4922-оор нэмэгдсэн ба *рашаан сувилал, хувийн үүдэн эмнэлэг, эмийн сангийн* өсөлт голлох байр суурийг эзэлж байна.

Дүрслэлээс харахад 2011 онд байгууллагын тоо харьцангуй олноор буюу урд оноос 227-оор нэмэгдсэн бол ажиллах хүчний хувьд жил тутам, дунджаар 1230.5-аар нэмэгдсэн байна.

2012 оны байдлаар улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн зарим байгууллагыг онцлон авч үзвэл:

- Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг 329.,
- Өрхийн эрүүл мэндийн төв 221.,
- Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг 34.,
- Бүсийн оношилгоо эмчилгээний төв 5.,
- Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв 16.,
- Хувийн ортой болон үүдэн эмнэлэг 1030.,
- Эм ханган нийлүүлэх болон эмийн үйлдвэр 197.,
- Хувийн эмийн сан 855.,
- Рашаан сувилал 100 байна.

Хүснэгт 2-оос харахад улсын эрүүл мэндийн байгууллагын хувьд тооны өсөлт, бууралтын хэлбэлзэл бага байна. Харин ажиллах хүчний тоо гуравдагч шатлалд бусад байгууллагаас харьцангуй өндөр буюу дунджаар 345-аар, мөн Анагаах ухааны коллежийн хүний нөөц 370-аар нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 2. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ БАЙРШИЛ- БАЙГУУЛЛАГААР

	Эрүүл мэндийн байгууллагууд	2009		2010		2011		2012	
		Байгууллагын Тоо	Хүний нөөцийн Тоо	Байгууллагын Тоо	Хүний нөөцийн Тоо	Байгууллагын Тоо	Хүний нөөцийн Тоо	Байгууллагын Тоо	Хүний нөөцийн Тоо
Анхдагч шатлалын эрүүл мэндийн байгууллага									
1	Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг	312	8100	311	8060	311	7992	310	8050
2	Өрхийн эрүүл мэндийн төв	226	2215	218	2265	219	2235	221	2377
3	Тосгоны эрүүл мэндийн төв	18	303	17	289	19	351	19	342
Хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллага									
4	Дүүргийн НЭ, НЭМТ	12	2531	12	2562	12	2637	12	2840
5	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	6	536	6	538	6	542	6	616
6	Аймгийн нэгдсэн эмнэлэг	17	4506	17	4476	17	4471	16	4438
Гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллага									
7	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	4	1501	4	1572	4	1555	5	1855
8	Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төв	16	5833	16	5794	16	5993	16	6169
Бусад эрүүл мэндийн байгууллага									
9	Амаржих газрууд	3	461	3	485	3	519	3	586
10	Хилийн цэрэг, төмөр замын эмнэлэг	49	1438	55	1531	47	1317	45	1366
11	Ортой хувийн эмнэлэг	160	1814	166	2115	171	2532	179	2806
12	Үүдэн хувийн эмнэлэг	922	1999	947	2199	1013	2310	851	2707
13	Яаралтай тусламжийн төв	1	234	1	285	1	296	1	356
14	БГХӨЭСТөв, алба	15	377	15	379	15	372	15	268
15	Цусны станц, ЦССҮТ	2	3	2	55	1	54	1	55
16	Рашаан сувилал	13	616	16	515	67	1065	100	1326
17	Эм ханган нийлүүлэх байгууллага	144	717	158	902	158	836	155	843
18	Эмийн үйлдвэр	57	601	41	356	42	423	42	353
19	Хувийн эмийн сан	636	2792	666	2884	703	3102	855	3544
20	ЭМЯ, ЭМХТ	2	181	2	178	2	159	2	199
21	Эрүүл мэндийн газар	22	706	22	723	22	732	22	781
22	Анагаах ухааны сургууль, коллеж	4	790	4	912	4	1059	4	1160
23	Эрдэм шинжилгээний байгууллагууд	1	144	1	138	1	129	1	158
24	Бусад газар	13	306	-	395	73	443	44	431
Бүгд		2655	38704	2700	39608	2927	41124	2925	43626

Байгууллагын тооны өсөлтөд шууд нөлөөлж буй рашаан сувилал, хувийн эмнэлэг, эмийн сангийн өсөлт нь нийт байгууллагын 67.8%-ийг эзэлж байгаа бол ажиллах хүчний хувьд 15.6%-ийг эзэлж байна. Тухайлбал: 2009 онд 13 байсан рашаан сувилал 2012 онд 100 болтлоо өссөн бол, эмийн сан 219-өөр тус тус өссөн байна. Харин хувийн үүдэн эмнэлгийн хувьд арай өөр дүр зураг харагдаж байна. Тухайлбал: Үүдэн эмнэлэг 2009 оноос 2011 онд 91-ээр өссөнөө, 2012 онд 2011 оноос 162-оор буурсан байна.


Харин ажиллах хүчний хувьд тоон үзүүлэлт буураагүй, тогтмол өссөн, суурь онтой харьцуулахад рашаан сувилалд 2.1 дахин, хувийн үүдэн эмнэлэгт 1.3 дахин, эмийн санд 1.2 дахин ажиллах хүчин нэмэгдсэн байна. 2009 оны үзүүлэлтийг суурь болгон, эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний тоо, өсөлтийн хувийг улсын (шатлалаар) болон хувийн хэвшлээр ангилан авч үзлээ.

ДҮРСЛЭЛ 5. АНХДАГЧ ШАТЛАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК




Анхдагч шатлал буюу сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн ажиллах хүчний 4 жилийн динамикт харьцангуй өөрчлөлт бага байснаа, 2012 онд 1.4%-иар, тоогоор авч үзвэл 151 хүнээр нэмэгдсэн байна.

ДҮРСЛЭЛ 6. ХОЁРДОГЧ ШАТЛАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК



Хоёрдогч шатлал буюу аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлгийн ажиллах хүчний 4 жилийн динамикт 2012 онд 4.2%-иар, тоогоор авч үзвэл 321 хүнээр нэмэгдсэн байна.

ДҮРСЛЭЛ 7. ГУРАВДАГЧ ШАТЛАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК



Гуравдагч шатлал буюу төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн ажиллах хүчний динамикаас харахад 2011:2012 онд 2.9:9.4 хувиар, тоогоор авч үзвэл 214:690 хүнээр нэмэгдсэн байна. Хувийн хэвшлийн ортой болон үүдэн эмнэлгийн ажиллах хүчний өсөлт улсын эмнэлгээс

харьцангуй өндөр буюу суурь онтой харьцуулахад 44.6%-иар өсчээ. Бодит тоогоор авч үзвэл 1700 хүнээр өссөн байна.

Товч дүгнэлт: Эрүүл мэндийн байгууллагын тооны өсөлтөд рашаан сувилал, хувийн үүдэн эмнэлэг, эмийн сангийн өсөлт голлох байр суурийг эзэлж байгаа ба үүдэн эмнэлгийн тоо харьцангуй буурах хандлагатай байна. Ажиллах хүчний тоо жил тутам нэмэгдсэн ба шатлалаар авч үзвэл гуравдагч шатлалд хамгийн их өссөн байна. Хувийн хэвшлийн хувьд рашаан сувилал, эмийн сангийн ажиллах хүчний тоо харьцангуй өндөр хувиар нэмэгдсэн байна.

Эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлтэд өнөөг хүртэл хилийн цэрэг, төмөр замын эмнэлэг, хорихын эмнэлгүүд, сургууль, ясли, цэцэрлэг, уурхай, мэргэжлийн хяналтын газар зэрэг өөр салбарын байгууллага, тэнд ажиллаж байгаа хүний нөөцийн үзүүлэлтийг бүртгэж ирсэн байна.

Энэ бүртгэл, мэдээллийг “Эрүүл мэндийн салбарын нийт ажилчин гэж авсан нь буруу бөгөөд, энэ нь дунджаар эрүүл мэндийн салбарын нийт ажилчдын тоог дунджаар 1800 орчим хүнээр зөрүүлэхэд (нэмэгдсэн) хүргэж байна.

3.1.3. Эрүүл мэндийн нийт ажиллах хүчний байршил, хангамжийн динамик- Мэргэжлээр

2012 оны байдлаар эрүүл мэндийн чиглэлээр ажиллаж буй нийт 43626 ажиллах хүчний 19.7% нь их эмч, 39.8% нь тусгай мэргэжлийн мэргэжилтэн, 28.2% нь бусад ажилтан, 12.3% нь бусад мэргэжилтэн байна.

Бусад мэргэжлээр авч үзвэл нийт ажиллах хүчний 1.8% нь удирдах ажилтан, 1.2% нь нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, 0.2% нь статистикч, 0.3% нь мэдээллийн технологийн мэргэжилтэн, 0.1% нь хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, 0.1% нь хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, 0.2% нь мэргэжлийн хяналтын албаны улсын байцаагч, 3.4% нь эм зүйч, 4.9% нь бусад мэргэжилтэн эзэлж байна.

Тусгай мэргэжлийн мэргэжилтнээр авч үзвэл, нийт ажиллах хүчний 22.7% нь сувилагч, 1.8% нь эх баригч, 2.4% нь багийн бага эмч, 3.9% нь бусад бага эмч, 0.5% нь шүдний техник, 2.2% нь лаборант, 0.4% нь гэрлийн техник, 5.2% нь эм найруулагч байна.

ДҮРСЛЭЛ 8. ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙТ АЖИЛЛАХ ХҮЧИН -МЭРГЭЖЛЭЭР



Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчнийг мэргэжлээр авч үзэхдээ анхдагч, хоёрдогч, гуравдагч шатлалаар харуулахыг зорьлоо.

Ингэхдээ эрүүл мэндийн үзүүлэлтээр гардаг 22 ангиллыг нэгтгэх байдлаар авч үзсэн ба тухайлбал: "Мэргэжилтэн"-д нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, статистикч их эмч, мэдээллийн технологийн мэргэжилтэн, хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, мэргэжлийн хяналтын албаны улсын байцаагчийг хамааруулан авлаа.

Өсөлтийг 2009 оныг суурь болгон, харьцуулан авч үзсэн болно. Хүснэгтээс харахад мэргэжилтэн гэсэн хэсэгт хамааруулан авсан нийгмийн эрүүл мэндийн ажилтан, статистик, мэдээлэл технологи, хоол тэжээл, хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн сүүлийн жилүүдэд өсч байгаатай уялдан хамгийн өндөр хувиар нэмэгдсэн харагдаж байна.

ХҮСНЭГТ 3. ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙТ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХАНГАМЖ -МЭРГЭЖЛЭЭР

Мэргэжил	2009		2010		2011		2012	
	тоо	өсөлт	тоо	өсөлт	тоо	өсөлт	тоо	өсөлт
1. Удирдах ажилтан	771	-	616	-20.1%	717	-7.0%	806	4.5%
2. Мэргэжилтэн	496	-	625	26.0%	780	57.3%	947	90.9%
3. Их эмч	7140	-	7497	5.0%	7943	11.2%	8597	20.4%
4. Эм зүйч, бусад дээд	2710	-	3086	13.9%	3249	19.9%	3612	33.3%
5. Сувилагч	9017	-	9179	1.8%	9420	4.5%	9916	10.0%
6. Эх баригч, бага эмч	3195	-	3286	8.3%	3429	8.3%	3493	8.0%
7. Шүд, гэрлийн техникч	340	-	349	2.9%	362	6.5%	392	15.3%
8. Лаборант	879	-	900	2.4%	931	5.9%	960	9.2%
9. Эм найруулагч, бусад	2358	-	2114	-10.3%	2345	-0.6%	2593	5.9%
10. Бусад ажилтан	11798	-	11956	1.3%	11948	1.3%	12310	4.3%
Нийт	38704	-	39608	-	41124	-	43626	-

ХҮСНЭГТ 4. АНХДАГЧ ШАТЛАЛЫН АЖИЛЛАХ ХҮЧИН-МЭРГЭЖЛЭЭР

Мэргэжил	2009		2010		2011		2012	
	тоо	өсөлт	тоо	өсөлт	тоо	өсөлт	тоо	өсөлт
1. Удирдах ажилтан	18	-	-	-	44	2.4	90	5.0
2. НЭМ-ийн мэргэжилтэн	20	-	44	2.2	46	2.3	52	2.6
3. Их эмч	1548	-	1587	1.0	1678	1.1	1628	1.1
4. Эм зүйч, бусад дээд	314	-	343	1.1	345	1.1	401	1.2
5. Сувилагч	2512	-	2472	1.0	2461	1.0	2519	1.1
6. Эх баригч, бага эмч	1958	-	2003	1.0	1983	1.0	1965	1.0
7. Шүд, гэрлийн техникч	11	-	8	-0.2	7	-0.6	6	-0.7
8. Лаборант	178	-	187	1.0	188	1.0	196	1.1
9. Эм найруулагч, бусад	265	-	244	-0.9	339	1.2	358	1.3
10. Бусад ажилтан	3794	-	3726	-1.0	3592	-0.9	3544	-0.9
Нийт	10618	-	10614	-	10578	-	10769	-

ХҮСНЭГТ 5. ХОЁРДОГЧ ШАТЛАЛЫН АЖИЛЛАХ ХҮЧИН-МЭРГЭЖЛЭЭР

Мэргэжил	2009		2010		2011		2012	
	тоо	өсөлт	тоо	өсөлт	тоо	өсөлт	тоо	өсөлт
1. Удирдах ажилтан	87	-	80	-0.9	83	-0.9	78	-1.0
2. НЭМ бусад мэргэжилтэн	36	-	37	1.0	43	1.1	50	1.2
3. Их эмч	1675	-	1693	1.0	1716	1.1	1807	1.2
4. Эм зүйч, бусад дээд	241	-	283	1.1	288	1.2	299	1.2
5. Сувилагч	2417	-	2426	1.0	2420	1.0	2519	1.1
6. Эх баригч, бага эмч	494	-	497	1.0	492	-0.9	534	1.1
7. Шүд, гэрлийн техникч	77	-	72	-0.9	69	-0.8	72	-0.9
8. Лаборант	271	-	267	-0.9	270	-0.9	268	-0.9
9. Эм найруулагч, бусад	133	-	70	-0.5	122	-0.9	110	-0.8
10. Бусад ажилтан	2142	-	2151	1.0	2115	-0.9	2112	-0.9
Нийт	7573	-	7576	-	7650	-	7894	-

ХҮСНЭГТ 6. ГУРАВДАГЧ ШАТЛАЛЫН АЖИЛЛАХ ХҮЧИН-МЭРГЭЖЛЭЭР

Мэргэжил	2009		2010		2011		2012	
	тоо	өсөлт	тоо	өсөлт	тоо	өсөлт	тоо	өсөлт
1. Удирдах ажилтан	83	-	74	-0.8	79	-0.9	82	-0.9
2. Мэргэжилтэн	32	-	33	1.0	34	1.0	45	1.4
3. Их эмч	1465	-	1526	1.0	1614	1.1	1739	1.2
4. Эм зүйч, бусад дээд	370	-	415	1.1	413	1.1	451	1.1
5. Сувилагч	2426	-	2426	1.0	2510	1.1	2653	1.1
6. Эх баригч, бага эмч	213	-	214	1.0	216	1.0	243	1.1
7. Шүд, гэрлийн техникч	78	-	76	1.0	79	1.0	84	1.1
8. Лаборант	235	-	226	-0.9	236	1.0	261	1.1
9. Эм найруулагч, бусад	171	-	85	-0.5	88	-0.6	86	-0.5
10. Бусад ажилтан	2261	-	2291	1.0	2231	-0.9	2317	1.0
Нийт	7334	-	7366	-	7548	-	8024	-

Хүснэгтүүдээс харахад ажиллах хүчний нийт өсөлт дунджаар 1.2 дахин өссөн, тусгай мэргэжлийн зарим мэргэжилтэн -0.8 дахин буурсан байдал ажиглагдаж байна.

ДҮРСЛЭЛ 9. ИХ ЭМЧИЙН БАЙРШИЛ, ХАНГАМЖИЙН ДИНАМИК



Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд их эмчийн тоо жил тутам нэмэгдэж, 2009 онтой харьцуулахад 2012 онд 20.4%-иар өссөн, 2009 оноос хойш гуравдагч шатлалд 270, анхдагч шатлалд 80, хоёрдогч шатлалд 132, хувийн эмнэлэгт 508 их эмч тус тус нэмэгдсэн байна.

2012 оны байдлаар улсын хэмжээнд 8597 их эмч ажиллаж байгааг 34 мэргэжлийн ангиллаар авч үзвэл эхний 5 байранд 11.2%-иар өрх, сумын, 9.8%-иар дотрын, мөн хувиар ерөнхий мэргэжлийн, 7.8%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 6.7%-иар хүүхдийн эмч орж байна.

Аймгаар авч үзвэл эхний 5 байранд 18.5%-иар ерөнхий мэргэжлийн, 13.8%-иар өрх, сумын, 9.3%-иар дотрын, 8.2%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 7.9%-иар хүүхдийн эмч орж байна.

ХҮСНЭГТ 7. ИХ ЭМЧ ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР (2012 ОН)

№	Мэргэжил	Улс			Аймаг			Улаанбаатар		
		Их эмчийн тоо	10000 хүн амд ногдох их эмчийн тоо	Тухайн оны нийт эмчид эзлэх хувь	Их эмчийн тоо	10000 хүн амд ногдох их эмчийн тоо	Тухайн оны нийт эмчид эзлэх хувь	Их эмчийн тоо	10000 хүн амд ногдох их эмчийн тоо	Тухайн оны нийт эмчид эзлэх хувь
1	Дотрын	844	3.0	9.8%	300	2.0	9.3%	544	4.2	10.2%
2	Хүүхдийн	577	2.0	6.7%	256	1.7	7.9%	321	2.5	6.0%
3	Эх барих эмэгтэйчүүдийн	672	2.4	7.8%	266	1.7	8.2%	406	3.1	7.6%
4	Мэс заслын	411	1.4	4.8%	137	0.9	4.2%	274	2.1	5.1%
5	Мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний	280	1.0	3.3%	80	0.5	2.5%	200	1.5	3.7%
6	Гэмтэл, согог заслын	148	0.5	1.7%	38	0.2	1.2%	110	0.8	2.1%
7	Хавдар судлаач	69	0.2	0.8%	26	0.2	0.8%	43	0.3	0.8%
8	Чих хамар хоолойн	140	0.5	1.6%	45	0.3	1.4%	95	0.7	1.8%
9	Нүдний	133	0.5	1.5%	48	0.3	1.5%	85	0.7	1.6%
10	Мэдрэлийн	270	1.0	3.1%	86	0.6	2.7%	184	1.4	3.4%
11	Сэтгэцийн эмгэг судлалын	136	0.5	1.6%	40	0.3	1.2%	96	0.7	1.8%
12	Шүд	740	2.6	8.6%	179	1.2	5.5%	561	4.3	10.5%
13	Эрүү нүүрний	56	0.2	0.7%	27	0.2	0.8%	29	0.2	0.5%
14	Уламжлалт анагаахын	477	1.7	5.5%	152	1.0	4.7%	325	2.5	6.1%
15	Зүү, төөнүүр заслын	52	0.2	0.6%	22	0.1	0.7%	30	0.2	0.6%
16	Сэргээн засах эмчилгээний	108	0.4	1.3%	21	0.1	0.6%	87	0.7	1.6%
17	Арьс гоо заслын	62	0.2	0.7%	11	0.1	0.3%	51	0.4	1.0%
18	Арьс харшлын	56	0.2	0.7%	22	0.1	0.7%	34	0.3	0.6%
19	Халдвартын	141	0.5	1.6%	59	0.4	1.8%	82	0.6	1.5%
20	Сүрьеэгийн	104	0.4	1.2%	44	0.3	1.4%	60	0.5	1.1%
21	Дүрс оношлогооны	304	1.1	3.5%	67	0.4	2.1%	237	1.8	4.4%
22	Лабораторийн	308	1.1	3.6%	76	0.5	2.3%	232	1.8	4.3%
23	Эмгэг судлаач, шүүхийн шинжээч	94	0.3	1.1%	25	0.2	0.8%	69	0.5	1.3%
24	Нефролог	39	0.1	0.5%	3	0.0	0.1%	36	0.3	0.7%
25	Уролог	25	0.1	0.3%	1	0.0	0.0%	24	0.2	0.4%
26	Хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	13	0.0	0.2%	6	0.0	0.2%	7	0.1	0.1%
27	Эрүүл ахуйч	41	0.1	0.5%	8	0.1	0.2%	33	0.3	0.6%
28	Дох/БЗДХ	80	0.3	0.9%	25	0.2	0.8%	55	0.4	1.0%
29	Тархвар судлаач	127	0.4	1.5%	28	0.2	0.9%	99	0.8	1.8%
30	Гоц халдвартын	29	0.1	0.3%	19	0.1	0.6%	10	0.1	0.2%
31	Мэргэжлийн шалтгаант эмгэгийн	5	0.0	0.1%	4	0.0	0.1%	1	0.0	0.0%
32	Өрх, сумын	965	3.4	11.2%	447	2.9	13.8%	518	4.0	9.7%
33	Ерөнхий мэргэжлийн эмч	840	3.0	9.8%	600	3.9	18.5%	240	1.8	4.5%
34	Бусад	251	0.9	2.9%	70	0.5	2.2%	181	1.4	3.4%
	Бүгд	8597	30.3	100.0%	3238	21.1	100.0%	5359	41.1	100.0%

Эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр эрүүл мэндийн байгууллагын хүний их эмчийг ажлын байрны нэрээр 34 ангилан авч үздэг. Энэ үзүүлэлтэд өрх, сумын эмч, ерөнхий мэргэжлийн эмч гэсэн ангилалд энэ чиглэлээр ажиллаж байгаа эмчийн тоо аймаг бүрт хэт зөрөөтэй.

Жишээлбэл: 2012 оны байдлаар Төв, Увс, Завхан, Сүхбаатар аймагт өрх, сумын эмч нь 3-5 хүн, ерөнхий мэргэжлийн эмч нь 25-52 байгаа бол Баянхонгор, Дорнод, Өвөрхангай, Говь-Алтай аймгуудад өрх, сумын эмч 47-58 хүн, ерөнхий мэргэжлийн эмч 2-10 хүн байх жишээтэй байна.

Энэ нь 2001 онд ЭМСХХ-ийн хүрээнд анх удаа өрхийн эмчийн 6 сарын эмнэл зүйн сургалт хийж, өрхийн эмчийн мэргэжлийн үнэмлэх олгосонтой нэг талаараа холбоотой боловч өнөөдрийн байдлаар ерөнхий мэргэжлийн эмчийн мэдээлэлтэй холилдсон, бодит тоон утга алдагдсан байна.

Улаанбаатар хотын хувьд эхний 5 байранд 10.5%-иар шүдний, 10.2%-иар дотрын, 9.7%-иар өрхийн, 7.6%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 6.1%-иар уламжлалт анагаахын эмч орж байна. Мэргэжил бүрээр 10000 хүнд ногдох байдлыг мэргэжлээр Улаанбаатар хотод 10000 хүнд шүдний эмч 4.3 ногдож байгаа нь хамгийн их байгаа ба хот, хөдөөд дотрын их эмч 2-4 ногдож байна.

ХҮСНЭГТ 8. ИХ ЭМЧ ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР –ШАТЛАЛААР (2012 ОН)

№	Мэргэжил	Анхдагч		Хоёрдогч		Гуравдагч	
		Их эмчийн тоо	Тухайн оны нийт эмчид эзлэх хувь	Их эмчийн тоо	Тухайн оны нийт эмчид эзлэх хувь	Их эмчийн тоо	Тухайн оны нийт эмчид эзлэх хувь
1	Дотрын	96	5.9%	193	10.7%	172	9.9%
2	Хүүхдийн	107	6.6%	205	11.3%	115	6.6%
3	Эх барих эмэгтэйчүүдийн	60	3.7%	178	9.9%	98	5.6%
4	Мэс заслын	30	1.8%	83	4.6%	141	8.1%
5	Мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний	5	0.3%	73	4.0%	136	7.8%
6	Гэмтэл, согог заслын	-	0.0%	40	2.2%	86	4.9%
7	Хавдар судлаач	-	0.0%	25	1.4%	28	1.6%
8	Чих хамар хоолойн	-	0.0%	44	2.4%	30	1.7%
9	Нүдний	1	0.1%	40	2.2%	33	1.9%
10	Мэдрэлийн	5	0.3%	78	4.3%	54	3.1%
11	Сэтгэцийн эмгэг судлалын	1	0.1%	35	1.9%	73	4.2%
12	Шүд	27	1.7%	76	4.2%	45	2.6%
13	Эрүү нүүрний	2	0.1%	14	0.8%	20	1.2%
14	Уламжлалт анагаахын	34	2.1%	46	2.5%	35	2.0%
15	Зүү, төөнүүр заслын	2	0.1%	10	0.6%	9	0.5%
16	Сэргээн засах эмчилгээний	-	0.0%	25	1.4%	36	2.1%
17	Арьс гоо заслын	1	0.1%	9	0.5%	32	1.8%
18	Арьс харшлын	-	0.0%	20	1.1%	10	0.6%
19	Халдвартын	3	0.2%	50	2.8%	59	3.4%
20	Сүрьеэгийн	-	0.0%	60	3.3%	29	1.7%
21	Дүрс оношлогооны	1	0.1%	84	4.6%	87	5.0%
22	Лабораторийн	1	0.1%	68	3.8%	111	6.4%
23	Эмгэг судлаач, шүүхийн шинжээч	-	0.0%	18	1.0%	37	2.1%
24	Нефролог	-	0.0%	2	0.1%	26	1.5%
25	Уролог	-	0.0%	-	0.0%	18	1.0%
26	Хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	-	0.0%	9	0.5%	2	0.1%
27	Эрүүл ахуйч	-	0.0%	10	0.6%	2	0.1%
28	Дох/БЗДХ	-	0.0%	30	1.7%	25	1.4%
29	Тархвар судлаач	-	0.0%	26	1.4%	73	4.2%
30	Гоц халдвартын	-	0.0%	-	0.0%	9	0.5%
31	Мэргэжлийн шалтгаант эмгэгийн	-	0.0%	2	0.1%	-	0.0%
32	Өрх, сумын	951	58.4%	6	0.3%	-	0.0%
33	Ерөнхий мэргэжлийн эмч	298	18.3%	168	9.3%	90	5.2%
34	Бусад	3	0.2%	80	4.4%	18	1.0%
Бүгд		1,628	100.0%	1,807	100.0%	1,739	100.0%

Шатлалаар, мэргэжил тус бүрээр авч үзвэл:

- Анхдагч шатлалд 58.4%-иар өрх, сумын, 18.3%-иар ерөнхий мэргэжлийн, 6.6%-иар хүүхдийн, 5.9%-иар дотрын, 3.7%-иар эх барих эмэгтэйчүүдийн.,
- Хоёрдогч шатлалд эхний 5 байранд 11.3%-иар хүүхдийн, 10.7%-иар дотрын, 9.9%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 9.3%-иар ерөнхий мэргэжлийн.,
- Гуравдагч шатлалд эхний 5 байранд 9.9%-иар дотрын, 8.1%-иар мэс заслын, 7.8%-иар мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний, 6.6%-иар хүүхдийн, 6.4%-иар лабораторын эмч нар орж байна.

Анхдагч шатлалд ажиллаж байгаа их эмчийг 2012 оны байдлаар байгууллагаар, мэргэжлээр авч үзвэл:

- *Их эмчийн ортой салбарт ажиллаж байгаа 8 их эмчийн 6 нь ерөнхий мэргэжлийн эмч байна.*
- *Тосгоны эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа 36 их эмчийн 12 нь дотрын, 8 нь ерөнхий мэргэжлийн, 5 нь хүүхдийн, 5 нь өрх сумын, эх баригч, эмэгтэйчүүд, мэс засал, уламжлалт анагаахын тус бүр 1, шүдний 3 эмч байна.*
- *Өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа 810 их эмчийн 91.5% нь өрхийн, 5.4% нь ерөнхий мэргэжлийн, 1.5% нь хүүхдийн, 0.7% нь дотрын эмч эзэлж байна.*
- *Сумын эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа 582 их эмчийн 30.2% нь сумын, 33.0% ерөнхий мэргэжлийн, 11.3% нь хүүхдийн, 10.0% нь дотрын, 6.7% нь эх барих, эмэгтэйчүүдийн, 3.6% нь уламжлалт анагаахын эмч нар байгаа нь дийлэнх хувийг эзэлж байна.*
- *Сум дундын эмнэлэгт ажиллаж байгаа 192 их эмчийн 25.5% нь ерөнхий мэргэжлийн, 14.6% нь өрх, сумын, 12.0% нь хүүхдийн, 10.9% нь мэс заслын, 10.4% нь эх барих эмэгтэйчүүдийн, 9.9% нь дотрын, 7.8% нь шүдний 3.6% нь уламжлалт анагаахын их эмч байна.*

Хоёрдогч шатлалд ажиллаж байгаа их эмчийг 2012 оны байдлаар байгууллагаар, мэргэжлээр авч үзвэл:

- *Хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт ажиллаж байгаа 118 их эмчийн 12.7% нь ерөнхий мэргэжлийн, 11.9% нь эх барих эмэгтэйчүүдийн, 10.2% нь дотрын, 9.3% нь мэс заслын, 7.6% нь хүүхдийн, 6.8% нь халдвартын, 5.1% нь шүдний, мөн хувиар лабораторын, 3.4% нь уламжлалт анагаахын, мөн хувиар мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний, чих, хамар хоолойн, 2.5% нь дүрс оношилгооны их эмч байна.*
- *Аймгийн нэгдсэн эмнэлэгт ажиллаж байгаа 904 их эмчийн 10.7% нь ерөнхий мэргэжлийн, 11.1% нь эх барих эмэгтэйчүүдийн, 8.7% нь дотрын, 8.2% нь хүүхдийн, 5.6% нь мэс заслын, 5.5% нь мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний, 4.1% нь мэдрэлийн, 4.1% нь дүрс оношилгооны, 3.8% нь лабораторын, 3.4% нь шүдний, 1.9% нь уламжлалт анагаахын их эмч байна.*
- *Дүүргийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа 785 их эмчийн 15.5% нь хүүхдийн, 13.0% нь дотрын, 8.2% нь эх барих эмэгтэйчүүдийн, 5.6% нь дүрс оношилгооны, 5.0% нь шүдний, 4.6% нь мэдрэлийн, 3.6% нь лабораторын, 3.2% нь уламжлалт анагаахын, 2.7% нь мэс заслын, 2.4% нь мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний, мөн хувиар чих хамар хоолойн, 2.2% нь гэмтэл, согог заслын, сэргээн засах эмчилгээний их эмч байна.*

Гуравдагч шатлалыг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөр ангилан авч үзвэл,

- *Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд 2012 оны байдлаар ажиллаж байгаа 1327 их эмчийн 9.8% нь дотрын, 8.7% мэс заслын, мөн хувиар мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний, 6.1% нь хүүхдийн, 5.7% нь гэмтэл, согог заслын эмч нар эзэлж байна.*
- *Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 412 их эмчийн 17.0% нь ерөнхий мэргэжлийн эмч, 10.2% нь дотрын, 9.0% нь эх барих, эмэгтэйчүүдийн, 8.3% нь хүүхдийн, 6.3% нь мэс заслын эмч байгаа нь эхний 5 байранд орж байна.*

Амаржих газруудад 2012 онд нийт 125 их эмч ажиллаж байгаагийн 56.8%-ийг эх барих, эмэгтэйчүүдийн эмч эзэлж, 18.4% нь хүүхдийн, 12.8% нь мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний, 3.2% нь дүрс оношилгооны, 2.4% нь лабораторын, 6.4% нь бусад мэргэжлийн их эмч нар байна.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 1904 их эмчийн 27.5% нь шүдний, 11.4% нь дотрын, 11.2% нь уламжлалт анагаахын, 10.9% нь эх барих, эмэгтэйчүүдийн, 4.7% нь дүрс оношилгооны, 4.4% нь мэс заслын, 4.3% нь хүүхдийн, 4.2% нь мэдрэлийн эмч нар эзэлж байна.

Үүдэн хувийн эмнэлгийн 1221 их эмчийн 41.4%-нь шүдний, 11.5% нь эх барих эмэгтэйчүүд эзэлж байгаа нь хамгийн өндөр хувь эзэлж байгаа бол, ортой хувийн эмнэлгийн 683 их эмчийн 22.0% нь дотрын, 12.7% нь уламжлалт анагаахын эмч нар эзэлж байгаа нь хамгийн өндөр хувь болж байна.

Товч дүгнэлт: *Аль ч шатлалд их эмчийн тоо тогтмол өссөн, ялангуяа гуравдагч шатлал, хувийн эмнэлэгт ажиллах их эмчийн тоо илүү өссөн, харин шүд, гэрлийн техникч, лаборант, эх баригч бага эмчийн тоо бага зэрэг буурсан байдал харагдлаа. Их эмчийг мэргэжлээр авч үзвэл Улаанбаатар хотод шүдний эмч, Аймагт ерөнхий мэргэжлийн эмч, Улсад өрх, сумын эмч олонх нь болж байна.*

3.1.4. Эрүүл мэндийн нийт ажиллах хүчний боловсрол, мэргэжлийн зэрэг

Эрүүл мэндийн стагтик үзүүлэлтэд боловсролын зэргийг доктор, анагаах ухааны боловсролын доктор, магистр гэж ангилан гаргасан байна.

2012 оны байдлаар эрүүл мэндийн салбарт доктор 228, анагаах ухааны боловсролын доктор 189, магистр 2249 байна. 4 жилийн динамик болон, тухайн жилд бүртгэгдсэн тоон мэдээллээс харахад боловсролын зэргийн бүртгэл, мэдээлэл бодит бус явагдаж ирсэн байна.

ХҮСНЭГТ 9. ЭРДМИЙН БОЛОН БОЛОВСРОЛЫН ЗЭРЭГТЭЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧИН

Боловсролын зэрэг	2009		2010		2011		2012	
	Бүгд	Тухайн онд	Бүгд	Тухайн онд	Бүгд	Тухайн онд	Бүгд	Тухайн онд
Доктор	74	8	132	22	184	50	228	56
Анагаах ухааны боловсролын доктор	152	10	174	17	167	16	189	14
Магистр	1488	37	2059	136	1912	249	2449	140

Хүснэгтээс харахад 2009 оны байдлаар доктор 8 байсан бол 2010 онд 22, 2011 онд 50, 2012 онд 56 гэсэн нь жилд дунджаар 34 хүн доктор хамгаалсан мэтээр харагдаж байна. Гэтэл анагаах ухааны боловсролын доктор нь доктороос тоогоор бага жилд дунджаар 14-15 хүн бүртгэгдсэн байна.

Өөрөөр хэлбэл жилд дунджаар 14 хүн анагаах ухааны боловсролын докторын, 34 хүн докторын зэрэг, цол хамгаалдаг мэтээр үзүүлэлт гарсан нь бүртгэл, мэдээлэл бодит бус, дүн шинжилгээ хийх боломжгүй болгож байна.

Мөн магистрийн зэрэгтэй хүмүүс 2009 оныг 2010 онтой харьцуулахад 571 хүнээр нэмэгдсэн, 2011 онд 2010 оноос 147 хүнээр буурсан, 2012 онд 537-оор нэмэгдсэн, тухайн онд нэмэгдсэн хүнээр авч үзвэл 2011 онд 249, 2012 онд 140 хүн нэмэгдсэн гэсэн нь мөн л мэдээлэл бодит бус байгааг харуулж байна. *Өөрөөр хэлбэл магиструуд 500-аар нэмэгдэж, эсвэл 100-аараа хасагдаж, тухайн ондоо 100 гаруй хүн магистр хамгаалсан мэт харагдаж байна.*

ХҮСНЭГТ 10. МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧИН


Мэргэжлийн зэрэг	2009		2010		2011		2012	
	Бүгд	Тухайн онд	Бүгд	Тухайн онд	Бүгд	Тухайн онд	Бүгд	Тухайн онд
Ахлах зэрэгтэй	1880	53	2283	545	2549	602	2841	560
Тэргүүлэх зэрэгтэй	860	24	1185	327	1364	230	1515	228
Зөвлөх зэрэгтэй	-	-	-	-	190	67	223	29

Эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн зэрэг хамгаалалт жилээс жилд өссөн байна. Гэхдээ урд онтой харьцуулсан үзүүлэлт, тухайн жилд шинээр бүртгэгдсэн тооны хоорондын зөрөө их байгаа нь мэдээлэл бодит бус байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 11. УДИРДАХ АЖИЛТАН, ИХ ЭМЧ, ТУСГАЙ МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ХАМГААЛАЛТ

Мэргэжил, боловсролын зэрэг	Удирдах				Их эмч				Тусгай мэргэжилтэн				
	2009	2010	2011	2012	2009	2010	2011	2012	2009	2010	2011	2012	
Мэргэжлийн зэрэг	Ахлах	25	34	43	46	946	1057	1001	1102	868	1132	1430	1630
	Тэргүүлэх	51	65	45	52	730	907	989	1030	64	182	286	371
	Зөвлөх	-	-	20	18	-	-	163	186	-	-	1	1
Боловсролын зэрэг	Магистр	76	110	110	104	1211	1487	1337	1806	46	31	20	28
	АУБ-ын доктор	18	43	44	50	115	108	109	113	-	-	-	-
	Доктор	18	33	38	48	48	72	118	109	-	1	1	1

ДҮРСЛЭЛ 10. УДИРДАХ АЖИЛТНЫ БОЛОВСРОЛЫН БОЛОН МЭРГЭЖЛИЙН ЗЭРГИЙН ДИНАМИК



2012 оны байдлаар эрүүл мэндийн удирдах ажилтны 5.7% нь ахлах, 6.5% нь тэргүүлэх, 2.2% нь зөвлөх зэрэгтэй, 12.9% нь магистр, 6.2% нь анагаах ухааны боловсролын доктор, 6.0% нь доктор байна. 4 жилийн динамикаар харахад жил тутам ахлах зэрэг нэмэгдсэн байна.

Товч дүгнэлт:

Өнөөг хүртэл эрүүл мэндийн статистик үзүүлэлтэд эрдмийн болон мэргэжлийн зэрэг цолтой хүмүүсээ буруу бүртгэдэг, мэдээлэлд дүн шинжилгээ хийдэггүй байсныг харуулж байна. Энэ нь эрүүл мэндийн салбарын хэмжээнд, эрүүл мэндийн ажиллах хүчнийхээ эрдмийн болон мэргэжлийн зэргийн хөгжлийг динамикаар харах боломжгүй, хуурамч тоотой явсаар ирсэн гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

БҮЛЭГ 3.2. ХҮН АМ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХАРЬЦАА

3.2.1. Олон улсын болон Монгол улсын 10000 хүнд ногдох эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн зарим үзүүлэлт, Монгол улсын нийт хүн ам -эрүүл мэндийн ажиллах хүчний харьцаа

Олон улсын болон Монгол улсын 10000 хүнд ногдох эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн зарим үзүүлэлт:

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан 2012 оны эрүүл мэндийн статистик мэдээллийг ашиглан, 10000 хүнд ногдох эрүүл мэндийн ажиллах хүчнийг өөрийн орны үзүүлэлттэй харьцуулан авч үзлээ.

ХҮСНЭГТ 12. ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН 10000 ХҮНД НОГДОХ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ ⁴

Ангилал	Их эмч	Сувилагч, эх баригч	Шүдний эмч	Эмзүйч	НЭМ-ийн ажилтан
Ядуу буурай	2.8	6.7	0.3	0.5	
Хөгжиж байгаа	10.1	16.8	0.9	3.5	0.6
Хөгжингүй	22.4	44.5	6.5	3.7	
Өндөр хөгжилтэй	28.6	78.6	9.1	8.9	
Дэлхийн дундаж	14	29.7	3	4.1	2.7
Монгол улс	30.3	37.6	2.6	5.2	1.8

⁴ Эрүүл мэндийн үзүүлэлт, 2012 он, хуудас 50

ХҮСНЭГТ 13. ДЭМБ-ЫН БҮС НУТГИЙН БОЛОН ОЛОН УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН 10000 ХҮНД НОГДОХ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ ^{5,6}

Бүсийн ангилал	Их эмч	Сувилагч эх баригч	Шүдний эмч	Эмзүйч	НЭМ-ийн ажилтан
Африк	2.3	10.9	0.3	0.8	
Америк	22.5	61.5	12	6.9	
Зүүн өмнөд Ази	5.4	13.3	0.7	3.8	0.9
Европ	33.3	74.7	4.9	5.4	
Газар дундын тэнгис	11	15.4	2	4	
НДББ-н орнуудын дундаж	15.2	19.5	-	4.4	7.9
Олон улсын дундаж	14.2	33.2	2.2	2.2	2.7
Монгол улс	30.3	37.6	2.6	5.2	1.8


2012 оны эрүүл мэндийн үзүүлэлтээр Монгол улсад 10000 хүнд 30.3 их эмч ногдож байгаа нь хөгжиж байгаа орнуудаас 3 дахин, хөгжингүй орнуудаас 1.4 дахин, өндөр хөгжилтэй орнуудаас 0.9 дахин, дэлхийн болон олон улсын дунджаас 2.1 дахин өндөр байна.

Монгол улсын 10000 хүнд 37.6 сувилагч, эх баригч мэргэжилтэн ногдож байгаа нь хөгжиж байгаа орнуудаас 2.2 дахин өндөр, хөгжингүй орнуудаас 1.2 дахин, өндөр хөгжилтэй орнуудаас 2.1 дахин бага байна. Харин дэлхийн дунджаас 1.2 дахин, олон улсын дунджаас 1.1 дахин өндөр байна.

Шүдний эмчийн хувьд Монгол улсын 10000 хүнд 2.6 эмч ногдож байгаа нь хөгжиж байгаа орнуудаас 2.8 дахин өндөр, өндөр хөгжилтэй орнуудаас 3.5 дахин, дэлхийн дунджаас 1.6 дахин бага байна.

Монгол улсын 10000 хүнд 5.2 эм зүйч ногдож байгаа нь хөгжиж байгаа, хөгжингүй орнуудаас 1.4 дахин, дэлхийн дунджаас 1.3 дахин, олон улсын дунджаас 2.4 дахин өндөр байна. НЭМ-ийн ажилтны хувьд 10000 хүнд 1.9 ногдож байгаа дэлхийн болон олон улсын дунджаас 1.5 дахин бага байна.

ДҮРСЛЭЛ 11. НОМХОН ДАЛАЙН БАРУУН БҮСИЙН ОРНУУДЫН 10000 ХҮНД НОГДОХ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ ⁷



ДЭМБ-ын эрүүл мэндийн статистикийн 2013 оны үзүүлэлтээс Номхон далайн баруун бүсийн зарим орнуудын үзүүлэлтийг өөрийн оронтой харьцуулан авч үзлээ. Монгол улс 10000 хүнд ногдох их эмчийн үзүүлэлтээр дээрх 9 орноос өндөр байна. Шинэ Зеланд улс сувилагч, эх баригчийн тоогоор бусад орноос хамгийн өндөр үзүүлэлтэй байна.

⁵ Эрүүл мэндийн үзүүлэлт, 2012 он, хуудас 50


⁶ WHO, World health statistics 2013 /128-р хуудас/

⁷ WHO, World health statistics 2013 /128-р хуудас/

Монгол улсын нийт хүн ам-Эрүүл мэндийн ажиллах хүчний харьцаа

Бид судалгаандаа Монгол улсын хүн амын өсөлтийн динамикийг эрүүл мэндийн ажиллах хүчний динамик, өсөлтийн хувиар харьцуулан авч үзлээ. Улсын хэмжээнд 10000 хүнд 153.6 эрүүл мэндийн ажиллах хүчин ногдож байгаа бол Улаанбаатар хотод 172.0, аймгийн дундаж 138.1 байна.

ДҮРСЛЭЛ 12. МОНГОЛ УЛСЫН ДУНДАЖ ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧИН



Дүрслэлээс харахад Монгол улсын хүн ам ба эрүүл мэндийн ажиллах хүчний тоо жил тутам нэмэгдсээр байна. 2009 оныг суурь болгон, сүүлийн 3 жилийн дунджаар авч үзэхэд хүн ам 43353-аар өсч байхад эрүүл мэндийн ажиллах хүчний тоо 1640-өөр өссөн байна.

Энэ үзүүлэлтийг хувиар авч үзвэл 2009, 2010 онд хүн амын тоо, эрүүл мэндийн ажиллах хүчний тооны өсөлтийн хувь ойролцоо түвшинд байсан бол, хүн амын тооны өсөлтийн хувиас, эрүүл мэндийн ажиллах хүчний өсөлтийн хувь 2011 онд 2.8%-иар, 2012 онд 4.2%-иар өндөр байна. 4 жилийн дунджаар хүн ам 1.6%-иар өсч байхад эрүүл мэндийн ажиллах хүчин 3.6%-иар өссөн байна.

Товч дүгнэлт:

Улсын хэмжээнд 10000 хүнд 153.6 эрүүл мэндийн ажиллах хүчин ногдож байгаа бол Улаанбаатар хотод 172.0, аймгийн дундаж 138.1 байна.

Монгол улсын 10000 хүнд ногдох их эмчийн тоо хөгжиж байгаа, хөгжингүй, өндөр хөгжилтэй орнууд болон дэлхийн, олон улсын дунджаас өндөр байна.

Сувилагч, эх баригч мэргэжилтэн өндөр хөгжилтэй орнуудаас бага, дэлхий, олон улсын дунджаас өндөр, шүдний их эмч, НЭМ-ийн ажилтан дэлхийн болон олон улсын дунджаас бага, харин эм зүйч бүх түвшинд өндөр байна.

Хүн ам өсөхийн хэрээр эрүүл мэндийн ажиллах хүчний тоо өсч, тоогоор авч үзвэл дунджаар 43353:1640, өсөлтийн хувиар 1.6%:3.6% гэсэн харьцаатай байна.

3.2.2. Аймаг, хотын хүн ам -Эрүүл мэндийн ажиллах хүчний харьцаа


Аймгуудын хүн амын тооны өсөлт, бууралтыг эрүүл мэндийн ажиллах хүчний өсөлт, бууралттай харьцуулан дүн шинжилгээ хийлээ. Хүснэгт 14-т эрүүл мэндийн ажиллах хүчнийг 10 мэргэжлээр ангилан, аймаг тус бүрээр илэрхийлэн, бодит тоогоор болон өсөлтийн хувиар илэрхийлэн, дүн шинжилгээ хийлээ.

ХҮСНЭГТ 14. АЙМГУУДЫН ХҮН АМ, ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ТОО, ӨСӨЛТ БУУРАЛТЫН ХУВЬ


Аймаг/хот	2009					2010					2011					2012				
	Хүн ам	Хүн амын өсөлтийн хувь	Ажилчдын тоо	Ажилчдын өсөлтийн хувь	10000 хүн амд ногдох ажилчид	Хүн ам	Хүн амын өсөлтийн хувь	Ажилчдын тоо	Ажилчдын өсөлтийн хувь	10000 хүн амд ногдох ажилчид	Хүн ам	Хүн амын өсөлтийн хувь	Ажилчдын тоо	Ажилчдын өсөлтийн хувь	10000 хүн амд ногдох ажилчид	Хүн ам	Хүн амын өсөлтийн хувь	Ажилчдын тоо	Ажилчдын өсөлтийн хувь	10000 хүн амд ногдох ажилчид
Абоаи аае	92,477	-0.2%	1,054	1.8%	114.0	92,041	-0.5%	1,119	6.2%	121.6	84,459	-8.2%	1,141	2.0%	135.1	84,765	0.4%	1,143	0.2%	134.8
Аагй -а өае	101,569	0.5%	1,008	1.8%	99.2	101,342	-0.2%	1,047	3.9%	103.3	88,478	-12.7%	1,048	0.1%	118.4	89,642	1.3%	1,061	1.2%	118.4
Аагй ои і ө	85,271	0.7%	1,031	-0.9%	120.9	85,249	0.0%	1,027	-0.4%	120.5	76,436	-10.3%	1,077	4.9%	140.9	77,249	1.1%	1,129	4.8%	146.2
Аооаи	61,883	1.5%	784	-0.4%	126.7	62,489	1.0%	774	-1.3%	123.9	53,909	-13.7%	785	1.4%	145.6	54,333	0.8%	801	2.0%	147.4
Аи аи-Аооае	59,599	-0.7%	999	2.4%	167.6	58,863	-1.2%	1,027	2.8%	174.5	53,259	-9.5%	1,036	0.9%	194.5	53,335	0.1%	1,046	1.0%	196.1
Аи аунгй аүд	13,085	2.9%	220	3.3%	168.1	13,533	3.4%	226	2.7%	167.0	13,591	0.4%	235	4.0%	172.9	14,084	3.6%	239	1.7%	169.7
Аадоаи-Ооө	89,118	1.4%	1,158	0.5%	129.9	90,889	2.0%	1,148	-0.9%	126.3	95,477	5.0%	1,222	6.4%	128.0	96,974	1.6%	1,292	5.7%	133.2
Аи өи і ө аи	57,788	2.4%	820	-1.2%	141.9	58,929	2.0%	856	4.4%	145.3	59,533	1.0%	868	1.4%	145.8	60,754	2.1%	925	6.6%	152.3
Аи өи і ө а	73,604	0.5%	954	5.0%	129.6	73,621	0.0%	948	-0.6%	128.8	69,883	-5.1%	956	0.8%	136.8	70,745	1.2%	1,007	5.3%	142.3
Аои өа аи	47,952	-1.1%	667	5.9%	139.1	46,993	-2.0%	659	-1.2%	140.2	38,227	-18.7%	633	-3.9%	165.6	37,750	-1.2%	690	9.0%	182.8
Сааоаи	79,565	-1.1%	1,082	2.2%	136.0	78,091	-1.9%	1,085	0.3%	138.9	64,796	-17.0%	1,095	0.9%	169.0	64,422	-0.6%	1,136	3.7%	176.3
И өои і	82,543	1.9%	1,004	-4.8%	121.6	84,444	2.3%	1,165	16.0%	138.0	91,218	8.0%	1,151	-1.2%	126.2	92,159	1.0%	1,236	7.4%	134.1
а өоаи аае	117,040	0.8%	1,188	4.2%	101.5	117,461	0.4%	1,223	2.9%	104.1	101,293	-13.8%	1,235	1.0%	121.9	101,686	0.4%	1,254	1.5%	123.3
а и ө а аи	48,517	2.6%	604	3.6%	124.5	50,173	3.4%	629	4.1%	125.4	62,509	24.6%	664	5.6%	106.2	64,400	3.0%	700	5.4%	108.7
Нг ооааао	54,942	-0.2%	749	5.8%	136.3	54,988	0.1%	763	1.9%	138.8	51,602	-6.2%	768	0.7%	148.8	52,214	1.2%	783	2.0%	150.0
Нүөйи аү	102,509	1.4%	1,113	1.0%	108.6	104,992	2.4%	1,131	1.6%	107.7	98,558	-6.1%	1,086	-4.0%	110.2	101,392	2.9%	1,090	0.4%	107.5
О а	87,639	1.5%	1,052	1.1%	120.0	89,364	2.0%	1,060	0.8%	118.6	85,558	-4.3%	1,134	7.0%	132.5	86,262	0.8%	1,168	3.0%	135.4
Оаи	79,299	-1.0%	966	1.6%	121.8	78,504	-1.0%	978	1.2%	124.6	73,106	-6.9%	982	0.4%	134.3	73,404	0.4%	1,016	3.5%	138.4
О аа	88,448	0.0%	968	1.9%	109.4	88,454	0.0%	1,002	3.5%	113.3	77,023	-12.9%	1,001	-0.1%	130.0	77,785	1.0%	1,057	5.6%	135.9
О аи өе	123,572	0.7%	1,370	0.7%	110.9	124,348	0.6%	1,392	1.6%	111.9	115,437	-7.2%	1,395	0.2%	120.8	116,790	1.2%	1,469	5.3%	125.8
Өйи өөе	71,232	0.1%	963	-1.9%	135.2	71,603	0.5%	966	0.3%	134.9	66,195	-7.6%	968	0.2%	146.2	66,957	1.2%	985	1.8%	147.1
Аеи өөеи аү	1,617,649	0.6%	19,754	1.3%	122.1	1,626,366	0.5%	20,225	2.4%	124.4	1,520,547	-6.5%	20,480	1.3%	134.7	1,537,096	1.1%	21,227	3.6%	138.1
Ооаи ааао	1,092,003	3.9%	18,950	2.7%	173.5	1,131,903	3.7%	19,383	2.3%	171.2	1,265,775	11.8%	20,644	6.5%	163.1	1,302,615	2.9%	22,399	8.5%	172.0
Өөни і аү	2,709,652	1.9%	38,704	2.0%	142.8	2,758,269	1.8%	39,608	2.3%	143.6	2,786,322	1.0%	41,124	3.8%	147.6	2,839,711	1.9%	43,626	6.1%	153.6

Аймгуудын хүн ам, эрүүл мэндийн ажиллах хүчний өсөлт, бууралтыг аймаг бүрээр харьцуулан дүн шинжилгээ хийх зорилгоор хүн ам-ажиллах хүчний тоо, өсөлт бууралтын хувь, 10000 хүн амд ногдох ажиллах хүчний динамикийг урд онуудтай нь харьцуулан гаргалаа.

ДҮРСЛЭЛ 13. АЙМГУУДЫН ДУНДАЖ ХҮН АМ -ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧИН



ДҮРСЛЭЛ 14. АЙМГУУДЫН ХҮН АМ -ЭРҮҮЛ МЭНДИЙН 10000 ХҮН АМД НОГДОХ АЖИЛЛАХ ХҮЧИН



2012 оны байдлаар аймгуудын хүн амын өсөлт, бууралт -0.6%-иас +3.6%-иар өссөн бол эрүүл мэндийн ажиллах хүчин 0.2%-иас 9.0% хүртэл өсчээ.

Аймгуудын дундаж хүн ам 2010 онд 2009 оноос 8717 хүнээр нэмэгдэж байсан бол 2011 онд хүн амын тоо бусад онуудаас хамгийн их буурсан, 105819-өөр буюу 6.5%-иар буурснаа 2012 онд 16549-өөр нэмэгдсэн байна.

Харин эрүүл мэндийн ажиллах хүчний тоо хүн амын өсөлт, бууралттай хамааралгүй, байнга өсөн нэмэгдсэн, 3 жилд дунджаар 500 орчим хүн нэмэгдэж байсан байна.

10000 хүнд ногдох эрүүл мэндийн ажилтны аймгуудын дундаж 138.1 байгаа ба дунджаар 101.392 хүн амтай Сэлэнгэ аймагт 107.5 байгаа нь хамгийн бага, 53335 хүн амтай Говь-Алтай аймагт 196.1 хүн ногдож байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

2012 оны байдлаар аймгуудын дунджаар 10000 хүнд 21.1 их эмч ногдож байгаа нь хөгжиж байгаа орнуудаас 2.1 дахин, дэлхийн болон олон улсын дунджаас 1.5 дахин өндөр байна. Мөн шүдний эмч 10000 хүнд 1.2 ногдож байгаа нь дэлхийн дунджаас 2.5 дахин, 1.8 олон улсын дунджаас 2.1 дахин бага байна.

НЭМ-ийн ажилтны хувьд 10000 хүнд 1.6 ногдож байгаа нь дэлхийн болон олон улсын дунджаас 1.7 дахин бага байна.

ХҮСНЭГТ 15. АЙМГУУДЫН АЖИЛЛАХ ХҮЧИН-МЭРГЭЖЛЭЭР

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн амын тоо
2009	Нийт аймаг	122	317	2812	915	4777	2771	108	504	830	6598	19754	1617649
2010		128	368	2932	1044	4783	2854	112	515	960	6529	20225	1626366
2011		119	428	3036	1094	4749	2955	117	519	1084	6379	20480	1520547
2012		122	439	3238	1211	4913	2981	123	529	1174	6497	21227	1537096

Аймгуудын ажиллах хүчинг мэргэжлээр авч 2012 оноос бусад онуудад үзвэл удирдах ажилтан, лаборант, сувилагч, эх баригч бага эмч, шүд, гэрлийн техникчийн мэргэжил хэлбэлзэл багатай байна. 2012 онд их эмч, сувилагч, эм найруулагчийн тоо нэмэгдсэн байна.



I. ХАНГАЙН БҮС

Эрүүл мэндийн ажиллах хүчин болон хүний их эмчийн байршил, хангамж, хэрэгцээ болон 10000 хүн амд ногдох үзүүлэлтийг аймаг бүрээр гарган, дүн шинжилгээ хийлээ. Аймгуудаар гаргахдаа бүсчлэн авч үзэв.

Архангай аймаг:

ХҮСНЭГТ 16. АРХАНГАЙ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	4	16	125	33	259	148	4	33	40	392	1054	92477
2010	5	17	136	49	255	163	4	33	50	406	1119	92041
2011	4	21	143	55	254	165	4	34	49	411	1141	84478
2012	4	16	147	57	262	163	4	34	52	408	1143	84765



Архангай аймгийн хүн амын динамик 0.2-8.2%-иар буурч байсан бол ажиллах хүчин 0.2%-6.2%-иар өсч байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан 134.8 байгаа нь улсын (153.6) дунджаас доогуур, аймгийн (138.1) дундажтай ойролцоо түвшинд байна.



Мэргэжлээр авч үзвэл удирдах ажилтан, сувилагч, техникч, лаборант мэргэжлийн ажиллах хүчний хэлбэлзэл бага, их эмч, эм зүйч, бусад дээд мэргэжилтний тоо өссөн байна.

Архангай аймгийн их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 18.4%-иар ерөнхий мэргэжлийн, 17.0%-иар дотрын, 11.6%-иар хүүхдийн, 10.2%-иар эх барих, эмэгтэйчүүд, 5.4%-иар мэс заслын их эмч эзлэж байгаа бол гэмтэл, согог засал, хавдар судлал, арьс харшил, нефролог, уролог, эрүүл ахуйч, мэргэжлийн шалтгаант эмгэгийн эмч байхгүй байна.

Баянхонгор аймаг:

ХҮСНЭГТ 17. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Баян-хонгор	6	16	104	49	246	153	5	19	42	391	1031	85271
2010		7	18	111	59	248	147	5	21	65	346	1027	85249
2011		7	23	125	63	253	162	5	20	51	368	1077	76436
2012		6	22	134	70	273	167	5	28	60	364	1129	77249





Баянхонгор аймгийн хүн амын динамик 2011 онд 10.3%-иар буурч, ажиллах хүчин 4.9%-иар өссөн байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан 146.2 байгаа нь улсын дунджаас доогуур, аймгийн дунджаас дээгүүр байна. Мэргэжлээр авч үзвэл их эмч, сувилагч, эм зүйч, бусад дээд мэргэжилтэн болон ажилтан тогтмол өссөн байна.

Баянхонгор аймгийн их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 36.6%-иар өрх, сумын, 9.7%-иар ерөнхий мэргэжлийн, 6.7%-иар эх барих, эмэгтэйчүүд, 5.2%-иар дотрын, мөн хувиар мэс заслын их эмч орж байгаа бол арьс харшил, нефролог, уролог, эрүүл ахуйч, мэргэжлийн шалтгаант эмгэг, гоц халдварт, тархвар судлаач эмч байхгүй байна.

Булган аймаг:

ХҮСНЭГТ 18. БУЛГАН АЙМГИЙН ХҮН АМ-ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Булган	5	18	94	33	186	124	4	12	20	288	784	61883
2010		10	15	91	38	186	129	2	17	28	263	774	58863
2011		15	22	101	35	196	125	1	15	27	258	785	53909
2012		16	23	108	34	198	121	2	17	31	262	801	54333





Булган аймгийн хүн ам 2011 онд 13.7%-иар буурсан бол, ажиллах хүчин 0.4%-2.0%-иар өссөн байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан 174.4 байгаа нь улсын дунджаас доогуур, аймгийн дунджаас дээгүүр байна. Мэргэжлээр авч үзвэл удирдах ажилтны тоо нэмэгдсэн, их эмч, сувилагчийн тоо бага зэрэг өссөн, бусад ажилтаны тоо буурсан байна.

Булган аймгийн их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 34.3%-иар өрх, сумын, 11.1%-иар дотрын, 7.4%-иар хүүхдийн, 6.5%-иар эх барих, эмэгтэйчүүд, 4.6%-иар мэс заслын, мөн хувиар шүдний их эмч орж байгаа бол арьс гоо засал, зүү төөнүүр, сэргээн засах, мэргэжлийн шалтгаант эмгэг, гоц халдвартын эмч байхгүй байна.

Орхон аймаг:

ХҮСНЭГТ 19. ОРХОН АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Орхон	5	22	224	51	321	67	14	27	55	218	1004	82543
2010		5	32	246	93	327	86	15	27	72	262	1165	84444
2011		3	32	252	78	315	120	15	27	66	243	1151	91218
2012		4	33	257	105	327	122	15	29	79	264	1236	92159



Орхон аймгийн хувьд хүн ам 2010-2012 онд тогтмол өссөн бол ажиллах хүчний өсөлт хэлбэлзэл ихтэй, 2010 онд хамгийн өндөр буюу 16.0%-иар өссөн байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан 134.1, аймгийн түвшинтэй ойролцоо байна.



Мэргэжлээр авч үзвэл их эмч, эм зүйч, бусад дээд, эх баригч бага эмчийн тоо өссөн, удирдах ажилтан, сувилагч, техникч, лаборант өсөлт, бууралт бага байна.

Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 16.7%-иар өрх, сумын, 10.1%-иар дотрын, мөн хувиар ерөнхий мэргэжлийн, 6.6%-иар эх барих, эмэгтэйчүүд, 3.5%-иар хүүхдийн, мөн хувиар мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний эмч орж байгаа бол уролог, эрүүл ахуйч, арьс гоо засал, гоц халдвартын эмч байхгүй байна.

Өвөрхангай аймаг:

ХҮСНЭГТ 20. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Өвөрхангай	9	13	173	51	277	174	4	23	48	416	1188	117040
2010		8	17	176	61	288	187	4	24	59	399	1223	117461
2011		7	20	180	65	285	183	6	23	75	391	1235	101293
2012		4	20	194	75	292	186	7	25	88	363	1254	101686



Өвөрхангай аймгийн хувьд хүн ам 2009-2010 онд ойролцоо түвшинд байснаа 2011 онд 13.8-иар буурсан бол, ажиллах хүчин өсөлт буурах хандлага ажиглагдаж байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан 123.3 улс, аймгийн дунджаас доогуур байна. Мэргэжлээр авч үзвэл их эмч, сувилагч, эм зүйч, бусад дээд мэргэжилтний тоо өссөн, удирдах ажилтан, бусад ажилтны тоо буурсан байна.

Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 29.9%-иар өрх, сумын, 9.8%-иар уламжлалт анагаахын, 9.3%-иар хүүхдийн, 8.8%-иар дотрын, 6.7%-иар эх барих,

эмэгтэйчүүдийн эмч орж байгаа бол нефрологи, уролог, эрүүл ахуйч, эмгэг судлал, шүүхийн шинжээч, хоол тэжээл хариуцсан мэргэжилтэн, мэргэжлээс шалтгаант эмгэгийн эмч байхгүй байна.

Хөвсгөл аймаг:

ХҮСНЭГТ 21. ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Хөвсгөл	6	21	160	49	322	240	6	40	79	447	1370	123572
2010		3	22	175	53	334	225	6	41	88	445	1392	124348
2011		8	23	172	57	305	261	5	40	89	421	1395	115437
2012		9	21	198	66	331	262	8	39	89	431	1469	116790



Хөвсгөл аймгийн хувьд хүн ам, ажиллах хүчний өсөлтийн динамик бага, ойролцоо түвшинд байснаа 2011 онд хүн амын өсөлт 7.2%-иар буурсан бол, ажиллах хүчин 2012 онд 5.2%-иар өссөн байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан 125.8 байгаа нь улс, аймгийн дунджаас доогуур байна. Мэргэжлээр авч үзвэл их эмчийн тоо өссөн, бусад ажилтан бага зэрэг буурсан боловч, бүсийн аймгуудаас тооны хувьд өндөр байна.


Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 26.3%-иар ерөнхий мэргэжлийн, 11.1%-иар хүүхдийн, 7.6%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 7.1%-иар дотрын, мөн хувиар шүдний эмч орж байгаа бол нефрологи, уролог, хоол тэжээл хариуцсан мэргэжилтэн, тархвар судлаач, мэргэжлээс шалтгаант эмгэгийн эмч байхгүй байна.

II. ТӨВИЙН БҮС

Сэлэнгэ аймаг:

ХҮСНЭГТ 22. СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Сэлэнгэ	11	24	165	48	280	140	6	32	57	350	1113	102509
2010		9	31	161	49	277	154	6	33	63	348	1131	104992
2011		8	13	166	46	262	151	6	36	55	343	1086	98558
2012		6	18	160	50	263	155	4	31	54	349	1090	101392





Сэлэнгэ аймгийн хувьд хүн ам 2011 онд 6.1%-иар, ажиллах хүчин 4.0%-иар буурсан байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан 107.5 байгаа нь бусад аймаг, улсын дунджаас харьцангуй доогуур байна. Мэргэжлээр авч үзвэл нийт ажиллах хүчин, их эмч, сувилагчийн тоо буурсан, ялангуяа их эмчийн тоо, хүн амтай харьцуулахад харьцангуй бага байна.

Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 19.4%-иар ерөнхий мэргэжлийн, 13.4%-иар хүүхдийн, 10.9%-иар дотрын, 7.6%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 6.6%-иар шүдний, мөн хувиар уламжлалт анагаахын эмч орж байгаа бол эрүү, нүүр, зүү төөнүүр, сэргээн засах, арьс харшил, нефрологи, уролог, хоол тэжээл хариуцсан мэргэжилтэн, эрүүл ахуй, тархвар судлаач, гоц халдварт, мэргэжлээс шалтгаант эмгэгийн эмч байхгүй байна. Энэ нь бусад аймгаас харьцангуй олон их эмч дутуу байгааг харуулж байна.

Дархан-Уул аймаг:

ХҮСНЭГТ 23. ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Дархан-Уул	2	9	231	57	327	101	9	29	69	324	1158	89118
2010		3	10	231	61	327	91	9	31	71	314	1148	90889
2011		5	12	242	76	337	105	9	32	83	319	1222	95477
2012		4	13	248	85	355	109	10	30	94	340	1292	96974



Дархан-Уул аймгийн хувьд 2011 онд хүн амын өсөлт болон ажиллах хүчин өсөлт хамгийн их буюу 5.0:6.4%-иар өссөн байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан 133.2, улсын дунджаас доогуур, аймгийн дундажтай ойролцоо байна. Мэргэжлээр авч үзвэл эмч, сувилагч бага зэрэг өссөн, хэлбэлзэл багатай байна.



Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 17.3%-иар өрх, сумын, 10.9%-иар ерөнхий мэргэжлийн, 8.5%-иар дотрын, мөн хувиар эх барих, эмэгтэйчүүдийн,

6.0%-иар хүүхдийн эмч орж байгаа бол нефрологи, уролог, хоол тэжээл хариуцсан мэргэжилтэн, эрүүл ахуй, гоц халдвартын эмч байхгүй байна.

Төв аймаг:

ХҮСНЭГТ 24. ТӨВ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Төв	4	20	131	55	235	136	4	27	32	408	1052	87639
2010		4	24	138	60	233	140	4	28	35	394	1060	89364
2011		6	30	154	78	243	144	3	27	49	400	1134	85558
2012		6	35	159	97	253	137	3	29	45	404	1168	86262





Төв аймгийн хувьд 2011 онд хүн ам 4.3%-иар буурсан байхад ажиллах хүчин 7.0%-иар өссөн, бусад онуудад хэлбэлзэл бага байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан 135.4, улсын дунджаас доогуур, аймгийн дундажтай ойролцоо байна.

Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 27.0%-иар ерөнхий мэргэжлийн, 10.1%-иар дотрын, мөн хувиар уламжлалт анагаахын, 9.4%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 6.9%-иар хүүхдийн, эмч орж байгаа бол нефрологи, уролог, эмгэг судлал, шүүхийн шинжээч, мэргэжлээс шалтгаант эмгэгийн эмч байхгүй байна.

Говьсүмбэр аймаг:

ХҮСНЭГТ 25 . ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Говьсүмбэр	2	6	41	9	53	33	1	6	9	60	220	13085
2010		5	8	39	10	52	30	2	6	13	61	226	13533
2011		4	10	45	9	53	29	2	6	16	61	235	13591
2012		2	8	48	9	58	31	2	6	14	61	239	14084





Говьсүмбэр аймгийн хувьд хүн ам болон эрүүл мэндийн ажиллах хүчний өсөлт хэлбэлзэл багатай, хүн ам 2009 онтой харьцуулахад 999-өөр өссөн бол ажиллах хүчин 19-өөр өссөн байна. Харин 10000 хүнд ногдох эрүүл мэндийн ажилтан 169.7 байгаа нь улс, аймгийн дунджаас өндөр байна.

Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 22.9%-иар өрх, сумын, 12.5%-иар ерөнхий мэргэжлийн, 10.4%-иар хүүхдийн, 6.3%-иар дотрын, мөн хувиар хүүхдийн эмч орж байгаа бол гэмтэл, согог засал, хавдар судлал, эрүү, нүүр, сэтгэц, эмгэг судлал, зүү төөнүүр, сэргээн засах, арьс гоо засал, нефрологи, уролог, хоол тэжээл хариуцсан мэргэжилтэн, эрүүл ахуй, тархвар судлаач, гоц халдварт, мэргэжлээс шалтгаант эмгэгийн эмч зэрэг мэргэжлийн эмч ажилладаггүй байна.

Дорноговь аймаг:

ХҮСНЭГТ 26. ДОРНОГОВЬ ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Дорноговь	6	16	178	55	174	93	3	15	41	239	820	57788
2010		9	17	184	51	185	88	3	13	49	257	856	58929
2011		11	22	179	59	179	91	3	10	52	262	868	59533
2012		15	27	183	85	178	90	5	11	60	271	925	60754



Дорноговь аймгийн хувьд хүн амын өсөлт хэлбэлзэл багатай 1.0-2.4% байгаа бол ажиллах хүчин 2012 онд хамгийн их буюу урд оноос 6.6% өссөн байна. 2009, 2012 оныг харьцуулахад хүн ам 2966-аар өссөн бол ажиллах хүчин 105-аар өссөн байна.



10000 хүнд ногдох эрүүл мэндийн ажилтан 152.3, улсын дундажтай ойролцоо, аймгийн дунджаас дээгүүр түвшинд байна.

Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 29.6%-иар өрх, сумын, 15.1%-иар ерөнхий мэргэжлийн, 7.5%-иар дотрын, 6.3%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 4.4%-иар мэс заслын, 3.8%-иар шүдний эмч зүү төөнүүр, нефрологи, уролог, хоол тэжээл хариуцсан мэргэжилтэн, гоц халдварт, мэргэжлээс шалтгаант эмгэгийн эмч зэрэг мэргэжлийн эмч ажилладаггүй байна.

Дундговь аймаг:

ХҮСНЭГТ 27. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Дундговь	3	13	91	23	147	107	3	19	26	235	667	47952
2010		4	11	88	26	148	103	2	18	24	235	659	46993
2011		3	13	84	26	138	102	2	18	22	225	633	38227
2012		3	18	99	29	144	106	3	17	33	238	690	37750




Дундговь аймгийн хувьд хүн амын өсөлт 2011 онд 18.7% буурсан бол, ажиллах хүчин 2012 онд 9.0% өссөн байна. 2009, 2012 оныг харьцуулан авч үзвэл хүн ам 10202-оор буурч, ажиллах хүчин 23-аар өссөн байна. 10000 хүнд ногдох эрүүл мэндийн ажилтан 182.8, улс, аймгийн дунджаас харьцангуй өндөр байна.

Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 29.3%-иар өрх, сумын, 11.1%-иар хүүхдийн, 8.1%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 7.1%-иар дотрын, 13.1%-иар бусад эмч орж байгаа бол зүү төөнүүр, сэргээн засах, нефрологи, уролог, хоол тэжээл хариуцсан мэргэжилтэн, эрүүл ахуй, тархвар гоц халдварт, мэргэжлээс шалтгаант эмгэгийн эмч ажилладаггүй байна.

Өмнөговь аймаг:

ХҮСНЭГТ 28. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Өмнөговь	7	12	106	38	125	103	5	14	28	166	604	48517
2010		5	16	117	45	123	11	8	15	30	159	629	50173
2011		4	26	119	43	138	102	10	19	32	171	664	62509
2012		4	20	135	42	157	107	7	17	38	173	700	64400



Өмнөговь аймгийн хувьд хүн ам, ажиллах хүчин тогтмол өссөн байна. Ялангуяа 2011 онд хүн ам 24.6%-иар, ажиллах хүчин 5.6-иар өссөн байна. 10000 хүнд ногдох эрүүл мэндийн ажилтан **108.7** байгаа нь улс, аймгийн дунджаас харьцангуй доогуур байна.



Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 32.6%-иар ерөнхий мэргэжлийн, 8.9%-иар хүүхдийн, 8.1%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 7.4%-иар өрх, сумын, 6.7%-иар дотрын эмч орж байгаа бол хавдар судлал, эрүү, нүүр, зүү төөнүүр, сэргээн засах, арьс гоо засал, нефрологи, уролог, мэргэжлээс шалтгаант эмгэгийн эмч ажилладаггүй байна.

III. БАРУУН БҮС

Баян-Өлгий аймаг

ХҮСНЭГТ 29. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК



Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Баян-өлгий	3	12	132	36	247	146	6	26	37	363	1008	101569
2010		14	13	144	45	251	143	7	32	37	361	1047	101342
2011		7	12	145	48	243	146	7	31	50	355	1048	88478
2012		8	13	145	44	245	170	7	32	40	354	1061	89642



Баян-Өлгий аймгийн хувьд хүн амын өсөлт 2011 онд 12.7%-иар буурсан бол ажиллах хүчний тоо, өсөлт хэлбэлзэл багатай байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан 146.2 байгаа нь улсын дунджаас доогуур, аймгийн дунджаас дээгүүр байна. Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 16.6%-иар дотрын, 14.5%-иар өрх, сумын, 11.7%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 9.7%-иар хүүхдийн, мөн хувиар ерөнхий мэргэжлийн эмч орж байгаа бол нефрологи, уролог, хоол тэжээл хариуцсан мэргэжилтэн, мэргэжлээс шалтгаант эмгэгийн эмч байхгүй байна.

Завхан аймаг:**ХҮСНЭГТ 30. ЗАВХАН АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК**

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Завхан	5	9	118	58	247	189	3	28	37	388	1082	79565
2010	Завхан	5	11	120	64	222	203	4	29	41	386	1085	78091
2011	Завхан	4	18	128	64	224	200	5	31	63	358	1095	64796
2012	Завхан	4	18	143	68	242	177	6	31	62	385	1136	64422




Завхан аймгийн хувьд 4 жилийн динамикаар хүн амын тоо тогтмол буурсан бол ажиллах хүчний тоо тогтмол өссөн, 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан **176.3** байгаа нь улс, аймгийн дунджаас харьцангуй өндөр байна.

Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 36.4%-иар ерөнхий мэргэжлийн, 8.4%-иар дотрын, 7.0%-иар хүүхдийн, 6.3%-иар хүүхдийн, 4.9%-иар мэдрэлийн эмч орж байгаа бол эмгэг судлал, зүү төөнүүр, сэргээн засах, нефрологи, уролог, хоол тэжээл хариуцсан мэргэжилтэн, эрүүл ахуй, ДОХ/БЗДХ-ын эмч ажилладаггүй байна.

Увс аймаг:**ХҮСНЭГТ 31. УВС АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК**

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Увс	12	16	116	42	242	172	4	26	33	303	966	79299
2010	Увс	7	18	122	47	244	155	3	25	53	304	978	78504
2011	Увс	7	22	120	45	241	160	3	24	64	296	982	73106
2012	Увс	6	22	136	50	231	155	3	29	93	291	1016	73404




Увс аймгийн хувьд 2009-2011 онд хүн амын тоо тогтмол буурсан бол ажиллах хүчний тоо тогтмол өссөн байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан 138.4, улсын дунджаас доогуур, аймгийн дундажтай ойролцоо түвшинд байна.

Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 25.7%-иар ерөнхий мэргэжлийн, 11.0%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 9.6%-иар хүүхдийн, 8.1%-иар дотрын, 6.6%-иар мэс заслын, мөн хувиар шүдний эмч орж байгаа бол гоц халдварт, мэргэжлээс шалтгаант эмгэгийн эмч байхгүй байна.


Ховд аймаг:

ХҮСНЭГТ 32. ХОВД АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Ховд	7	12	123	45	251	154	7	31	39	299	968	88448
2010		7	17	148	41	248	171	11	33	33	293	1002	88454
2011		5	20	149	61	233	197	10	33	48	245	1001	77023
2012		5	19	169	64	232	201	10	33	52	272	1057	77785



ДҮРСЛЭЛ 49. ХОВД АЙМГИЙН ХҮН АМ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧИД




Ховд аймгийн хувьд 2011 онд хүн ам 12.9% буурсан бол ажиллах хүчин 2012 онд 5.6%-иар өссөн байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан 135.9, улсын дунджаас доогуур, аймгийн дундажтай ойролцоо түвшинд байна.

Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 27.2%-иар ерөнхий мэргэжлийн, 10.7%-иар дотрын, 8.9%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 6.5%-иар мэс заслын, 5.9%-иар хүүхдийн орж байгаа бол эрүүл ахуй, гоц халдварт, мэргэжлээс шалтгаант эмгэгийн эмч байхгүй байна.

Говь-Алтай аймаг:

ХҮСНЭГТ 33. ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Говь-Алтай	8	12	115	68	223	160	6	32	42	333	999	59599
2010		7	11	124	72	223	180	5	32	41	332	1027	58863
2011		5	14	138	75	227	177	5	32	41	322	1036	53259
2012		5	17	149	75	229	178	6	33	37	317	1046	53334



Говь-Алтай аймгийн хувьд хүн амын өсөлт тогтмол буурсан бол ажиллах хүчний өсөлт ч төдийлөн нэмэгдээгүй байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан **196.1** байгаа нь улс, аймгийн дунджаас харьцангуй өндөр байна.



Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 32.9%-иар ерөнхий мэргэжлийн, 9.4%-иар хүүхдийн, 7.4%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 6.0%-иар шүдний, 4.0%-иар дотрын, мөн хувиар мэс засал, уламжлалт анагаахын эмч орж байгаа мэргэжлээс шалтгаант эмгэгийн эмч байхгүй, бусад бүх мэргэжлийн эмч ажиллаж байна.

IV.ЗҮҮН БҮС

Дорнод аймаг:

ХҮСНЭГТ 34. ДОРНОД АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Дорнод	6	18	138	28	227	106	7	25	32	367	954	73604
2010		7	25	134	29	231	104	7	20	38	353	948	73621
2011		7	27	138	23	241	98	8	21	53	340	956	69983
2012		8	27	159	26	243	102	7	21	54	360	1007	70745





Дорнод аймгийн хувьд хүн амын өсөлт 2011 оноос бусад онуудад харьцангуй ойролцоо түвшинд байгаа бол 2012 онд ажиллах хүчин 5.3% өссөн байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан 142.3 байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна.

Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 22.9%-иар өрх, сумын, 15.1%-иар ерөнхий мэргэжлийн, 7.5%-иар дотрын, 6.3%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 4.4%-иар мэс заслын эмч орж байгаа бол зүү төөнүүр, нефрологи, уролог, хоол тэжээл хариуцсан мэргэжилтэн, эрүүл ахуй, гоц халдвартын эмч ажилладаггүй байна.


Сүхбаатар аймаг:

ХҮСНЭГТ 35. СҮХБААТАР АЙМГИЙН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн амын тоо
2009	Сүхбаатар	8	17	101	36	167	100	2	19	31	268	749	54942
2010		6	17	106	41	160	114	2	20	33	264	763	54988
2011		5	20	112	41	157	112	5	20	36	260	768	61602
2012		8	18	115	43	166	116	5	19	36	257	783	52214



ДҮРСЛЭЛ 56. СҮХБААТАР АЙМГИЙН ХҮН АМ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧИН





Сүхбаатар аймгийн хувьд хүн амын 2011 оноос бусад онд хэлбэлзэл багатай, ажиллах хүчин ч төдийлөн нэмэгдээгүй байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан 150.0 байгаа нь улс, аймгийн дунджаас өндөр байна.

Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 21.7%-иар ерөнхий мэргэжлийн, 11.3%-иар хүүхдийн, 10.4%-иар дотрын, мөн хувиар эх барих, эмэгтэйчүүдийн, 5.2%-иар шүдний эмч орж байгаа бол нефрологи, уролог, хоол тэжээл хариуцсан мэргэжилтэн, гоц халдварт, мэргэжлээс шалтгаант эмгэгийн эмч ажилладаггүй байна.

Хэнтий аймаг:

ХҮСНЭГТ 36. ХЭНТИЙ ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн амын тоо
2009	Хэнтий	3	15	146	51	221	125	5	21	33	343	963	71232
2010		3	17	141	50	221	130	3	17	37	347	966	71603
2011		4	21	144	51	225	125	3	20	45	330	968	66195
2012		6	23	152	44	234	126	3	18	46	333	985	66957




Хэнтий аймгийн хувьд 2011 оноос бусад онд хүн амын өсөлт хэлбэлзэл багатай, ажиллах хүчний өсөлт төдийлөн нэмэгдээгүй 0.1-1.2%-тай байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан **147.1** байгаа нь улсын дунджаас доогуур, аймгийн дунджаас дээгүүр байна.

Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 26.3%-иар ерөнхий мэргэжлийн, 9.9%-иар хүүхдийн, 9.2%-иар дотрын, 7.9%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 4.6%-иар мэс заслын эмч орж байгаа бол нефрологи, уролог, хоол тэжээл хариуцсан мэргэжилтэн, тархвар судлаач, мэргэжлээс шалтгаант эмгэгийн эмч ажилладаггүй байна.

V. УЛААНБААТАР ХОТ:

ХҮСНЭГТ 37. УЛААНБААТАР ХОТЫН ХҮН АМ- ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ДИНАМИК

Он	ХОТ	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн амын тоо
2009	УБ	649	179	4328	1795	4240	424	232	375	1528	5200	18950	1092003
2010		488	257	4565	2042	4396	432	237	385	1154	5427	19383	1131903
2011		598	352	4907	2155	4671	474	245	412	1261	5569	20644	1265775
2012		684	508	5359	2401	5003	512	269	431	2680	5813	22399	1302615





Улаанбаатар хотын хүн ам тогтмол өссөн ба ялангуяа 2011 онд 11.78%-иар өссөн бол энэ онд дийлэнх аймгийн хүн ам буурсан үзүүлэлттэй байна.

Их эмчийг 2012 оны байдлаар, мэргэжил бүрээр авч үзвэл эхний 5 байранд 10.5%-иар шүдний, 10.2%-иар дотрын, 7.6%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 6.1%-иар уламжлалт анагаахын эмч орж байна. Улаанбаатар хотын их эмчийн үзүүлэлтэд мэргэжлээс шалтгаант эмгэгийн эмч бүртгэгдээгүй байна.

Улаанбаатар хотод эрүүл мэндийн ажиллах хүчин 2011-2012 онд 6.5-8.5%-иар өссөн байна. 10000 хүн амд ногдох эрүүл мэндийн ажилтан **172.0** байгаа нь улс, аймгийн дунджаас дээгүүр байна.

2012 оны байдлаар Улаанбаатар хотын 10000 хүнд 44.1 их эмч ногдож байгаа нь хөгжиж байгаа орнуудаас 4.4 дахин, хөгжингүй орнуудаас 2.0 дахин, өндөр хөгжилтэй орнуудаас 1.5 дахин, дэлхийн болон олон улсын дунджаас 3.1 дахин өндөр байна.

Улаанбаатар хотод 10000 хүнд 42.3 сувилагч, эх баригч ногдож байгаа нь хөгжиж байгаа орнуудаас 2.5 дахин өндөр, хөгжингүй орнуудаас 1.0 дахин, өндөр хөгжилтэй орнуудаас 1.9 дахин бага байна. Харин дэлхийн дунджаас 1.4 дахин, олон улсын дунджаас 1.3 дахин өндөр байна.

Улаанбаатар хотод шүдний эмч 10000 хүнд 4.3 ногдож байгаа нь дэлхийн болон олон улсын дунджаас 2.1 дахин өндөр байна. Мөн 10000 хүнд 8.9 эм зүйч ногдож байгаа нь дэлхийн дунджаас 2.2 дахин, олон улсын дунджаас 4.0 дахин өндөр байна. НЭМ-ийн ажилтны хувьд 10000 хүнд 2.2 ногдож байгаа нь дэлхийн болон олон улсын дунджаас 1.2 дахин бага байна.

2009 оныг суурь он болгон Улаанбаатар хотыг 9 дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн ажиллах хүчний тоог, дүүргийн хүн амын тоотой дүүрэг тус бүрээр харьцуулан авч үзвэл ажиллах хүчний өсөлт хамгийн бага нь 1 хүн, хамгийн олон нь 73 хүнээр нэмэгдсэн, ажиллах хүчний өсөлт харилцан адилгүй байна. Гэхдээ хэлбэлзэл багатай байна.

Тухайлбал Баян зүрх дүүрэгт ажиллах хүчин 73-аар нэмэгдэж, хүн амын тоо 46264-өөр нэмэгдсэн нь хамгийн олон хүн болж байна. Багахангай дүүрэг ажиллах хүчин 1 хүнээр нэмэгдэж, хүн ам 166-аар буурсан нь хамгийн бага үзүүлэлт болж байна. Аймгуудтай харьцуулан харахад ажиллах хүчний тоон өсөлт бага, дунджаар 31.8-аар нэмэгдэж байхад, Багахангайгаас бусад дүүргийн дунджаар хүн ам 16,549.5-аар нэмэгдэж байна.

Товч дүгнэлт:

2012 оны байдлаар 10000 хүнд ногдох эрүүл мэндийн нийт ажиллах хүчний улсын дундаж 153.6, аймгийн дундаж 138.1, Улаанбаатар хотын дундаж 172.0 байна.

Аймгуудын дундаж хүн амд болон 10000 хүнд ногдох эрүүл мэндийн ажиллах хүчний тоо харилцан адилгүй., Тухайлбал: Дундговь, Булган, ГовьСүмбэр, Сүхбаатар, Говь-Алтай зэрэг хүн ам харьцангуй цөөн буюу 14.084-54.333 хүн амтай аймгуудын 10000 хүн амд 147.4-196.1 эрүүл мэндийн ажилтан ногдож байхад 90.000 дээш хүн амтай Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудад 10000 хүн амд 107.5-133.2 ажилтан ногдож байна.

1.302.615 хүн амтай Улаанбаатар хотын 10000 хүнд 172.0 эрүүл мэндийн ажилтан ногдож байгаа ба энэ нь аймаг, улсын дунджаас дээгүүр байна. Өөрөөр хэлбэл эрүүл мэндийн ажиллах хүчний өсөлт нь хүн амын өсөлт, бууралттай харилцан хамаарал багатай, цөөхөн хүн амтай аймгуудад олон хүн амтай аймгуудаас ажиллах хүчний тоогоор илүү, шилжилт, хөдөлгөөн их байсан ч орон тоо буураагүй, байнга өсөж байсан байна.

БҮЛЭГ 3.3. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ХАРЬЯА ЛАВЛАГАА ТӨВҮҮДИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИ БА ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

3.3.1. УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ (УНТЭ)

Хүний нөөцийн хангамж, чадавхи:

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь 2012 оны байдлаар удирдах ажилтан 10, статистицик эмч 3, мэдээлэл, технологийн мэргэжилтэн 3, хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн 1, их эмч 162, эм зүйч 10, бусад дээд мэргэжилтэн 33, тусгай мэргэжлийн мэргэжилтэн 329, үүнээс сувилагч 286, лаборант 21, бага эмч 3, гэрлийн техникч 10, эм найруулагч 8, бусад ажилтан 179, бүгд **730** ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

Их эмчийг мэргэжлээр ангилан авч үзвэл их эмчийн 22.8% нь дотрын, 15.4% нь мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний, 12.9% нь нефрологи, урологийн, 10.4% нь дүрс оношилгооны, 9.2% нь мэс заслын, 4.9% нь мэдрэлийн, мөн хувиар нүдний, 3.7% нь уламжлал, сэргээн засах, мөн хувиар чих хамар хоолойн, 3.0% нь шүд, эрүү нүүрний чиглэлээр ажиллаж, арьс, харшлын 1 эмчтэй байна.

ХҮСНЭГТ 38. УНТЭ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН

	Эрдмийн болон мэргэжлийн зэрэг цол	Мэргэжилтний тоо			
		Их эмч	Бусад дээд мэргэжилтэн	Сувилагч	Тусгай мэргэжилтэн
2	Шинжлэх ухааны доктор		1		
3	Анагаах ухааны доктор	8	-		
4	Магистр	47	-	1	
5	Зөвлөх зэрэгтэй	11	-		
6	Тэргүүлэх зэрэгтэй	43	-	29	5
7	Ахлах зэрэгтэй	25	-	96	6
8	Сурган заах арга зүйн эрх авсан, мэргэшсэн	24	-	2	-

УНТЭ-ийн эрдмийн зөвлөл нь 17 хүний бүрэлдэхүүнтэй, их эмчийн 34.6% нь эрдмийн болон боловсролын, 48.7% нь мэргэжлийн зэрэгтэй, сувилагч, тусгай мэргэжлийн мэргэжилтний 41.3% нь мэргэжлийн зэрэгтэй, 1 сувилагч магистр хамгаалсан байна. Сурган заах арга зүйн чиглэлээр 26 хүн мэргэшиж, эрх авсан байна.

УНТЭ -ийн нийт ажилчдын 84.7%-ыг эмэгтэйчүүд эзэлж, насны бүлгээр авч үзвэл нийт ажиллах хүчний **48.2%** нь 20-39 насны залуучууд, 35.6% нь 40-54 насныхан эзэлж байгаа бол их эмчийн 50.6% нь 20-39 насны залуучууд, 35.2% нь 40-49 насныхан, 10.5% нь 50-54 насныхан, 55 ба түүнээс дээш насны **6** их эмч ажиллаж, нийт эмчийн 67.2% нь эмэгтэйчүүд байна.

Ажилласан жилийн туршлагаар авч үзвэл их эмчийн 23.6% нь 5 жил хүртэл, 22.3% нь 6-10 жил, 25.4% нь 11-20 жил, 24.8% нь 21-30 жил, 3.7% нь 31-ээс дээш жил, ажилласан байна. Сувилагчийн 26.5% нь 5 жил хүртэл, 10.5% нь 6-10 жил, 23.7% нь 11-20 жил, 20.6% нь 21-30 жил, 10.1% нь 31-ээс дээш жил ажилласан, ажлын туршлагатай байна.

ХҮСНЭГТ 39. УНТЭ-ИЙН ИХ ЭМЧИЙН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ

№	Төрөлжсөн мэргэжлээр мэргэшсэн байдал	Их эмчийн тоо	Хаана суралцаж эзэмшсэн
Нийгмийн эрүүл мэндийн чиглэл			
1	Эрүүл мэндийн удирдлага	6	Удирдлагын академи, БНСУ
2	Тархвар зүй	2	ЭМШУИС
3	Биостатистик, мэдээлэл зүй	1	ЭМШУИС
4	Хоол судлал	1	ЭМШУИС
Дотор судлал			
5	Зүрх судас судлал	8	УНТЭ
6	Хэрлэг, үе мөчний өвчин судлал	2	УНТЭ
7	Амьсгалын замын өвчин судлал	8	УНТЭ, ЭМШУИС
8	Бөөрний өвчин судлал	8	УНТЭ- БНСУ, Япон улс
9	Хоол боловсруулах замын өвчин судлал	9	УНТЭ
10	Цусны өвчин судлал	6	УНТЭ, БНСУ
11	Дотоод шүүрлийн булчирхайн	4	УНТЭ
12	Хоол эмчилгээ судлал	1	-

13	Эмнэлзүйн харшил судлал	2	Арьсны эмгэг судлалын төв
14	Яаралтай тусламж, судлал	5	УНТЭ
15	Эрэгтэйчүүдийн өвчин судлал	1	УНТЭ
16	Гемодиализ судлал	4	УНТЭ, Хятад, Япон
17	Элэгний эмгэг судлал	3	УНТЭ
Мэс заслалын өвчин судлал			
18	Цээжний хөндийн мэс засал	1	УНТЭ, БНСУ
19	Хэвлийн хөндийн мэс засал	4	УНТЭ, Швейцарь, БНСУ
20	Ходоод, улаан хоолойн мэс засал	2	УНТЭ, Швейцарь, Австри, БНСУ
21	Бүдүүн, шулуун гэдэсний мэс засал	6	УНТЭ
22	Мэдрэлийн мэс засал	1	БНСУ
23	Бөөрний мэс засал	8	УНТЭ, Хятад, БНСУ
24	Судасны мэс засал	1	Швейцарь
25	Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал	8	БНСУ, Хятад
26	Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал	2	УНТЭ, БНСУ
27	Үений дурангийн мэс засал	1	БНСУ
28	Дотоод шүүрлийн мэс засал	2	УНТЭ
29	Уушигны мэс засал	2	УНТЭ
Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээ			
30	Эрчимт эмчилгээ судлал	8	Швейцарь, Австри
31	Өвдөлт судлал	2	Швейцарь
32	Амь тэнссэн үеийн анагаах ухаан	1	БНСУ
Сэтгэцийн эмгэг судлал			
33	Сэтгэл засал судлал	1	ЭМШУИС
Нүдний өвчин судлалын чиглэл			
34	Нүдний мэс засал судлал	6	АНУ, БНСУ
Чих, хамар хоолойн өвчин судлал			
35	Чих, хамар хоолойн мэс засал судлал	7	УНТЭ, БНСУ, Итали
36	Сонсгол судлал	1	УНТЭ, Герман, Япон
Уламжлалт анагаах ухааны чиглэл			
37	Уламжлалт анагаах ухааны эм зүй, жор	2	ЭМШУИС
Сэргээн засах анагаах ухаан			
38	Физик эмчилгээ судлал	1	ЭМШУИС, БНСУ
39	Дотрын өвчний сэргээн засал судлал	1	ЭМШУИС, БНСУ
Дүрс оношилгоо			
40	Эмэгтэйчүүдийн мэс засал	8	ЭХЭМҮТ
41	Цөмийн оношилгоо судлал	4	Герман, Австри, Австрали, Англи
42	Рентген онош зүй	6	УНТЭ, Япон, БНСУ
43	Соронзон давтамжит томографи судлал	1	БНСУ
44	Дурангийн онош зүй	4	УНТЭ, БНСУ

УНТЭ-т үндсэн 10 чиглэлээр, 44 төрөлжсөн мэргэжлээр 152 их эмч мэргэшсэнээс дотор судлалын 13 төрөлжсөн мэргэжлээр 61 эмч, мэс заслын өвчин судлалын 12 төрөлжсөн мэргэжлээр 38 эмч, дүрс оношилгооны 5 чиглэлээр 23 мэргэжлийн эмч тус тус ажиллаж байгаа нь дийлэнх буюу 80.2%-ийг эзэлж байна.

Их эмчийн дийлэнх нь өөрийн эмнэлэг дээр мэргэжил эзэмшсэн байна. Мөн гадаад харилцаа сайтай, цөөнгүй эмч БНСУ, БНХАУ, Япон, Швейцарь, Герман, Австри, Австрали, Англи зэрэг өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлсэн, ялангуяа БНСУ-д илүү олон хүн суралцсан байна.

ХҮСНЭГТ 40. УНТЭ-ИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ХЭРЭГЦЭЭ

№	Төрөлжсөн мэргэшлийн нэр	Суралцах хүний тоо	Хаана суралцах	
			Гадаад	Дотоод
1	Эрчимт эмчилгээний эмч	2	БНСУ	
2	Гастроэнтеролог /гастроскопи, колоноскопи/	2	БНСУ	
3	Гепатолог /элэг шилжүүлэн суулгасны дараах хяналтын менежмент/	1	БНСУ	
4	Торлогийн мэс засал эмчилгээ /surgical retina/	2	БНСУ	
5	Нүдний эвэрлэгийн оношилгоо, эмчилгээ /Cornea/	1	БНСУ	
6	Нүдний даралтын оношилгоо, эмчилгээ /glaucoma/	1	БНСУ	
7	Нүдний нөхөн сэргээх оношилгоо, эмчилгээ /Oculaplastic/	1	БНСУ	
8	Халдвар судлаач эмч	1	БНСУ	
9	Чих хамар хоолой /хамрын дурангийн мэс засал, хамрын гоо сайхны ба чихний микро мэс засал/	5	БНСУ	
10	Уламжлалт эмчилгээ /зүү, төөнө засал/	2	БНСУ	
11	Бөөрний мэс засал / лапароскопийн мэс заслын сургалт/	2	БНСУ	
12	Мэдрэлийн мэс заслын мэдээгүйжүүлэг, өвдөлт намдаалтын	1	БНСУ	

	менежмент			
13	Уушигны мэдээгүйжүүлэг	1	БНСУ	
14	Бүдүүн гэдэсний дурангийн мэс засал	2	БНСУ	
15	Бүдүүн шулуун гэдэсний дурангийн мэс засал /anal surgery/	1	БНСУ	
16	Эмнэлгийн чанарын удирдлага	1	БНСУ	
17	Эрүү нүүрний мэс засал	1	БНСУ	
18	Дүрс оношилгоо	1	БНСУ	
19	Эмнэлгийн мэдээлэл технологийн сүлжээний чиглэл	1	БНСУ	
20	Эмнэлгийн мэдээлэл технологийн програмын чиглэл	1	БНСУ	
21	Уушигны дуран	1	БНСУ	

УНТЭ-т дэвшилтэт технологийн нэвтрэлттэй холбоотойгоор 21 төрөлжсөн мэргэжлээр 31 эмчийг БНСУ-д мэргэшүүлэхээр төлөвлөсөн байна.

УНТЭ-т тусламж, үйлчилгээний ачаалал, дэвшилтэт технологитой уялдан 429 хүн нэмэх шаардлагатай 250 нь сувилагч, 73 нь сувилагчийн туслах байна. Дээд мэргэжлийн мэргэжилтний хувьд мэс заслын эмч, эмнэл зүйн эм судлаач, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникч, лабораторын их эмч, лаборант мэргэжлээр тус тус 9-11 хүн шаардлагатай байгаа нь олонхи болж байна.

Тусламж үйлчилгээ: УНТЭ нь 2012 оны байдлаар амбулаториор нийт 216186 үзлэг хийсний 93.9% нь амбулаторын үзлэг, 6.0% нь урьдчилан сэргийлэх үзлэг байдаг ба идэвхтэй хяналт хийдэггүй байна. Тухайн онд 544 оронд 20917 хүн хэвтэн эмчлүүлсэний 48.8% нь хөдөөнөөс ирсэн, дундаж ор хоног 8.1, нийт ор хоног 168397, орны фонд ашиглалт 309.6 байна. 2012 онд 304 хүн нас барсны 24.7% нь хоног болоогүй нас баралт байна.

Нийт 7849 удаа мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлсний 18.2% нь глауком болон нүдний бусад мэс засал, 9.6% нь эрүү нүүрний мэс засал, 8.5% нь хамар хоолойн мэс засал, 7.1% нь судасны, 7.0% нь цөсний замын мэс засал хийсэн нь эхний 5 байранд орж байна. Мөн 2012 онд элэгний мэс засал 57 хүнд, бөөр авах мэс засал 180 хүнд, үе мөчний мэс засал 226 хүнд хийжээ. Тухайн онд 2337 мэс ажилбар хийсний 57.4% нь дурангийн мэс засал эзэлж байгаа ба үүний 56.5% нь шээс бэлгэсийн, 43.3% нь хоол боловсруулах эрхтний мэс ажилбарууд байна.

Лабораторын шинжилгээгээр бүгд 180191 шинжилгээ хийгдсэний 37.3% нь гематологийн, 45.8% нь клиникийн химийн, 16.9% нь микробиологийн шинжилгээнүүд эзэлж байгаа ба *чөмөгний шинжилгээ 292 хүнд, молекул биологийн шинжилгээ 780 хүнд хийжээ.*

УНТЭ нь сүүлийн жилүүдэд оношилгоо, эмчилгээний цөөнгүй шинэ технологиудыг амжилттай нэвтрүүлсэн байна. Тухайлбал:

- Эрхтэн шилжүүлэн суулгах (элэг, бөөр) мэс заслын технологи, хагалгааны дараах орчин үеийн ICU-н үйл ажиллагаа
- Хэвлийн хөндийн дурангийн хагалгаанд (улаан хоолой, ходоод, бүдүүн гэдэс) нэвтэрсэн дурангийн шинэ технологи
- Ясны чөмөг, цусны үүдэл эс шилжүүлэн суулгах вакуум иж бүрдэл тоног төхөөрөмж бүхий шинэ төв
- Түнх болон өвдөгний үе шилжүүлэн суулгах хагалгааны технологи
- Эмнэлгийн яаралтай тусламжийн иж бүрэн үйлчилгээ
- Гемодиализын орчин үеийн стандартын менежмент
- ICU-Эрчимт эмчилгээний үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, тоног төхөөрөмж, зохион байгуулалтын цогц менежмент
- Эд нийцэл, молекул генетик, гистологи, эмнэлзүйн бактериологийн лаборатори
- Евро стандартыг хангасан эмнэлгийн ариутгалын вакуум өрөө, чиглэсэн урсгал бүхий орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан-Ариутгалын тасгийн цогц шинэчлэл
- Судсан доторхи мэс ажилбарт радиологийн технологи зэрэг дэвшилтэт технологи, үйл ажиллагааг нэрлэж байна.

3.3.2. УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ (УХТЭ)

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь 2012 оны байдлаар удирдах ажилтан 4, статистицик эмч 2, мэдээлэл, технологийн мэргэжилтэн 2, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн 1, их эмч 75, эм зүйч 6, бусад дээд мэргэжилтэн 20, тусгай мэргэжлийн мэргэжилтэн 158, үүнээс сувилагч 142, лаборант 10, бага эмч 1, гэрлийн техникч 3, эм найруулагч 2, бусад ажилтан 143, бүгд 411 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 41. УХТЭ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН

	Эрдмийн болон мэргэжлийн зэрэг цол	Мэргэжилтний тоо			
		Их эмч	Бусад дээд мэргэжилтэн	Сувилагч	Тусгай мэргэжилтэн
1	Шинжлэх ухааны доктор	-	-	-	-
2	Анагаах ухааны доктор	5	-	-	-
3	Магистр	9	-	1	-
4	Зөвлөх зэрэгтэй	3	-	-	-
5	Тэргүүлэх зэрэгтэй	24	-	46	-
6	Ахлах зэрэгтэй	15	-	9	-
7	Сурган заах арга зүйн эрх авсан, мэргэшсэн	-	-	-	-

УХТЭ нь ЭМШУИС-ийн 7 эрдэмтэн, профессор болон байгууллагын 5 доктор, 3 профессор, нийт 15 хүнээс бүрдсэн эрдмийн зөвлөлтэй. УХТЭ-ийн их эмчийн 18.6% нь эрдмийн болон боловсролын, 56.0% нь мэргэжлийн зэрэгтэй, сувилагчийн 38.7% нь мэргэжлийн зэрэгтэй байна. Сурган заах арга зүйн чиглэлээр мэргэшсэн тоо, баримт ирүүлээгүй байна.

УХТЭ -ийн нийт ажилчдын 81.9%-ыг эмэгтэйчүүд эзэлж, насны бүлгээр авч үзвэл нийт ажиллах хүчний 43.8% нь 20-39 насны залуучууд, 46.9% нь 40-54 насныхан эзэлж байгаа бол их эмчийн 56.0% нь 20-39 насны залуучууд, 25.3% нь 40-49 насныхан, 13.3% нь 50-54 насныхан, 55 ба түүнээс дээш насны 4 их эмч ажиллаж, 61.3% нь эмэгтэйчүүд байна.

Ажилласан жилийн туршлагаар авч үзвэл их эмчийн 39.2% нь 5 жил хүртэл, 36.5% нь 6-10 жил, 16.2% нь 11-20 жил, 5.4% нь 21-30 жил, 2.7% нь 31-ээс дээш жил, ажилласан байна. Сувилагчийн 31.6% нь 5 жил хүртэл, 23.2% нь 6-10 жил, 23.9% нь 11-20 жил, 11.3% нь 21-30 жил, 9.8% нь 31-ээс дээш жил ажилласан, ажлын туршлагатай байна.

ХҮСНЭГТ 42. УХТЭ-ИЙН ИХ ЭМЧИЙН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ

Сэтгэцийн эрүүл мэнд судлалын чиглэлээр бүх эмч нар мэргэшсэн ба донтох эмгэг судлал, сэтгэл засал судлал, шүүхийн сэтгэцийн эмгэг судлал, сэтгэцийн нийгмийн сэргээн засах судлал, бэлгийн сэтгэцийн эмгэг судлал гэсэн 5 чиглэлээр бүх эмч нар төрөлжсөн мэргэжил эзэмшсэний 69.1% нь сэтгэл засал судлалаар мэргэшсэн байна. Мэргэжил эзэмших болон дээшлүүлэхдээ дийлэнх нь өөрийн эмнэлэг болон ЭМШУИС-ийн мэргэжил дээшлүүлэх институтийн сургалтад хамрагдсан ба ОХУ-д цөөн хүн суралцсан байна.

ХҮСНЭГТ 64. СЭМҮТ-ИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ХЭРЭГЦЭЭ

№	Төрөлжсөн мэргэшлийн нэр	мэргэжилтний тоо	Хаана, ямар сургалтын байгууллагад суралцах	
			Гадаадад	Дотоодод
1.	Эмгэг сэтгэл судлал	1-20 хүртэл	ОХУ	СЭМҮТ
2	Шүүхийн сэтгэц эмгэг судлал	1-10 хүртэл	ОХУ	СЭМҮТ
3	Ахмад настны сэтгэцийн эрүүл мэнд	10 хүртэл	Австрали	СЭМҮТ
4	Донтох эмгэг судлал	10 хүртэл	Австрали	СЭМҮТ
5	Психосоматик анагаах ухаан	10 хүртэл	Япон, Солонгос	СЭМҮТ
6	Сэтгэц засал	10 хүртэл	ОХУ	СЭМҮТ
7	Хүүхдийн сэтгэц эмгэг судлал	10 хүртэл	Солонгос, Энэтхэг улс	СЭМҮТ

Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр 7 үндсэн чиглэлийн хүрээнд 1-20 хүнийг өөрийн байгууллагадаа 6 сарын хугацаатайгаар, ОХУ, Австрали, Япон, Солонгос, Энэтхэг улсад 3 сарын хугацаатайгаар суралцуулах хэрэгцээтэй гэсэн байна. Хүүхдийн сэтгэцийн эмгэг судлал, өтлөлтийн сэтгэцийн эмгэг судлал, сэтгэцийн эм судлалаар мэргэшсэн эмч байхгүй байна.

Ажиллах хүчний ачаалал, хэрэгцээгээр СЭМҮТөвд шаардлагатай байгаа орон тоо сэтгэцийн эмч 15, рентгений их эмч 1, яаралтай тусламжийн эмч 1, хоол судлаач эмч 1, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер 4, мэдээллийн технологийн ажилтан 4, дэмжих үйлчилгээний ажилтан 35, нийт 57 хүн ажиллах хүчин шаардлагатай байна.

Тусламж, үйлчилгээ:

СЭМҮТ нь 2012 оны байдлаар амбулаториор нийт 64205 үзлэг хийсний 11.6% нь амбулаторын үзлэг, 48.2% нь урьдчилан сэргийлэх үзлэг, 40.2% нь идэвхтэй хяналт байна. Тухайн онд 450 оронд 5762 хүн хэвтэн эмчлүүлсний 34.3% нь хөдөөнөөс ирсэн, дундаж ор хоног 19.7, орны фонд ашиглалт 252.8, нийт ор хоног 113777 байна. 2012 онд 4 нас баралттай байна.

Лабораториор 15560 шинжилгээ хийгдсэний 36.4% нь гематологийн, 62.8% нь клиникийн химийн, 0.7% нь микробиологийн шинжилгээнүүд эзэлж байна. СЭМҮТ нь хэвтэн эмчлүүлэгчдийн аюулгүй байдлыг ханган тасаг, нэгжийг камержуулсан, яаралтай тусламжийн тасгийг шинээр эрэмбэлэн зохион байгуулсан, сэтгэц нийгмийн нөхөн сэргээх эмчилгээний шинэ аргууд нэвтрүүлэн, барилгын материал үйлдвэрлэлийн орчин бий болгосон зэрэг ажлын туршлагауд байна.

3.3.10. ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ (ГҮТ)

Геронтологийн үндэсний төв нь 2012 оны байдлаар удирдах ажилтан 2, НЭМ-ийн мэргэжилтэн 2, мэдээлэл, технологийн мэргэжилтэн 1, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн 1, их эмч 5, бусад дээд мэргэжилтэн 4, тусгай мэргэжлийн мэргэжилтэн 2, үүнээс сувилагч 2, бусад ажилтан 6, нийт 23 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 65. ГҮТ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН

	Эрдмийн болон мэргэжлийн зэрэг цол	Мэргэжилтний тоо			
		Их эмч	Бусад дээд мэргэжилтэн	Сувилагч	Тусгай мэргэжилтэн
1	Шинжлэх ухааны доктор	-	-	-	-
2	Анагаах ухааны доктор	2	-	-	-
3	Магистр	-	1	-	-
4	Зөвлөх зэрэгтэй	1	-	-	-
5	Тэргүүлэх зэрэгтэй	1	-	-	-
6	Ахлах зэрэгтэй	1	-	-	-
7	Сурган заах арга зүйн эрх авсан, мэргэшсэн	-	-	-	-

ГҮТ-ийн их эмчийн 25.0% нь боловсролын, 37.5% нь мэргэжлийн зэрэгтэй, сурган заах арга зүйгээр мэргэшсэн эмч байхгүй байна. ГҮТ-ийн нийт ажиллах хүчний 56.5%-ыг эмэгтэйчүүд эзэлж, 56.5% нь 20-39 насны залуучууд, 39.1% нь 40-54 насныхан эзэлж байна.

Ажилласан жилийн туршлагаар авч үзвэл их эмчийн 37.5% нь 1-5 жил, 25.0% нь 6-10 жил, 12.5% нь 16-20 жил, 25.0% нь 21 ба түүнээс дээш жил ажилласан байна.

ХҮСНЭГТ 66. ГҮТ-ИЙН ИХ ЭМЧИЙН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ

№	Төрөлжсөн мэргэжлээр мэргэшсэн байдал	Их эмчийн тоо	Хаана, ямар сургалтын байгууллагад суралцаж эзэмшсэн
Дотор судлал			
1	Зүрх судас судлал	1	ЭМШУИС-ийн МДИ
2	Настны өвчин судлал	1	ЭМШУИС-ийн МДИ
Арьсны өвчин судлал			
3	Арьсны харшил судлал	1	АӨСҮТ, ЭМШУИС-МДИ
Мэдрэлийн өвчин судлал			
4	Эмнэлзүйн нейрофизиологи судлал	2	УГТЭ, УНТЭ, ЭМШУИС-МДИ
Сэргээн засах анагаах ухааны судлал			
5	Мэдрэлийн сэргээн засал судлал	1	ЭМШУИС
Дүрс оношилгоо			
6	Дурангийн онош зүй	1	ЭМШУИС-МДИ

ГҮТ-д ажиллаж байгаа эмч нар зүрх судас, настны өвчин судлал, арьсны харшил судлал, мэдрэл, дүрс оношилгооны чиглэлээр ЭМШУИС болон УНТЭ, УГТЭ-т мэргэжил эзэмшсэн байна. Дэвшилтэт технологитой уялдан шинээр мэргэшүүлэх хэрэгцээ, шаардлага бага байна. Харин сэтгэцийн эмгэг судлаач, чих хамар хоолойн, нүдний, ревматологи, хөдөлгөөн засалч мэргэжлийн эмч нар шаардлагатай байна.

Тусламж, үйлчилгээ: ГҮТ нь 2012 оны байдлаар 11449 хүнийг амбулаториор хүлээн авсны 58.2% нь амбулаторын үзлэг, 38.1% нь урьдчилан сэргийлэх, 2.8% нь гэрийн идэвхитэй эргэлт байна. Төв нь “Гериатрийн шилжилтийн үеийн тусламж үйлчилгээ” шинэ загвар гарган туршиж эхэлсэн байна.

3.3.11. ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ (ЭСҮТ)

Хүний нөөцийн хангамж, чадаехи:

Эмгэг судлалын үндэсний төв нь 2012 оны байдлаар удирдах ажилтан 2, статистикийн эмч 1, их эмч 24, бусад дээд мэргэжилтэн 5, лаборант 17, бусад ажилтан 7, бүгд 56 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 67. ЭСҮТ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН

	Эрдмийн болон мэргэжлийн зэрэг цол	Мэргэжилтний тоо		
		Их эмч	Бусад дээд мэргэжилтэн	Тусгай мэргэжилтэн
1	Шинжлэх ухааны доктор	-	-	-
2	Анагаах ухааны доктор	3	-	-
3	Магистр	7	1	-
4	Зөвлөх зэрэгтэй	-	-	-
5	Тэргүүлэх зэрэгтэй	3	-	-
6	Ахлах зэрэгтэй	8	-	12
7	Сурган заах арга зүйн эрх авсан, мэргэшсэн	2	-	-

ЭСҮТ-ийн их эмчийн 41.6% нь боловсролын, 45.8% нь мэргэжлийн зэрэгтэй, тусгай мэргэжилтний 70.5% нь ахлах зэрэгтэй байна.

ЭСҮТ-ийн нийт ажилчдын 71.4%-ыг эмэгтэйчүүд эзэлж, насны бүлгээр авч үзвэл их эмч, бусад дээд мэргэжилтний 26.9% нь 20-29 насныхан, 23.0% нь 30-39 насныхан, 11.5% нь 40-49 насныхан, 15.3% нь 50-54 насныхан, 23.0% нь 55 ба түүнээс дээш насныхан эзэлж байна. Тусгай мэргэжлийн мэргэжилтний 39.0% нь 40-49 насныхан байна.

Ажилласан жилийн туршлагаар авч үзвэл их эмч, бусад дээд мэргэжилтний 23.0% нь 5 жил хүртэл, 19.2% нь 6-10 жил, 15.4% нь 11-15 жил, мөн хувиар 26-30 жил, 26.9% нь 31-ээс дээш жил ажилласан байна. Тусгай мэргэжлийн мэргэжилтний 39.1% нь 16-25 жил ажилласан байна.

ХҮСНЭГТ 68. ЭСҮТ-ИЙН ИХ ЭМЧИЙН ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ

№	Төрөлжсөн мэргэжлээр мэргэшсэн байдал	Их эмчийн тоо	Хаана, ямар сургалтын байгууллагад суралцаж эзэмшсэн
Эмгэг судлал			
1	Эмгэг анатомич	2	АУДэС
2	Эмгэг анатомийн эмч	2	АУДэС /курст суусан 1980 онд/
3	Эмгэг анатомич, шүүх эмнэлгийн эмч	1	АУДэС /курст суусан 1983 онд/
4	Эмгэг анатоми, шүүх эмнэлгийн эмч	1	АУДэС /курст суусан 1986 онд/
5	Эмгэг судлалын мэргэжилээр	1	АУИС
6	Патоанатоми шүүх эмнэлэг	1	ЭМШУИС-ийн МДИ
7	Эмгэг судлаач, шүүх эмнэлгийн эмч	3	ЭМШУИС-ийн МДИ
8	Эс судлаач эмч	1	Эс судлалын нийгэмлэг
9	Эмгэг судлаач эмч	8	Эмгэг судлалын үндэсний төв

Эмгэг судлалын чиглэлээр эс судлал, эмгэг судлал, эмгэг анатомич, патоанатоми гэсэн үндсэн 4 чиглэлээр, эмгэг анатомич, эмгэг анатомич-шүүх эмнэлгийн чиглэлээр 6, эмгэг судлал, эмгэг судлаач-шүүх эмнэлгийн чиглэлээр 12, эс судлал, патоанатомичоор тус тус 1 хүн мэргэшсэн байна. Өөрөөр хэлбэл их эмчийн 60.0% нь эмгэг судлаач, 30.0% нь эмгэг анатомич байгаа бол эс судлал, патоанатомичоор нэг, нэг хүн ажиллаж байна.

Эмгэг судлалын үндэсний төв нь эмгэг судлаач эмчийг өөрийн байгууллагад мэргэшүүлэн, эмгэг анатоми, шүүх эмнэлгийн эмчийг ЭМШУИС-ийн мэргэжил дээшлүүлэх институтад суралцуулдаг байна. Гадаад оронд мэргэжил дээшлүүлсэн эмч байхгүй, ялангуяа эмгэг анатомич мэргэжлийг 1980-1986 онд курсээр мэргэжил олж авсан гэжээ.

Тусгай мэргэжлийн мэргэжилтний хувьд эмгэг судлал, шүүх эмнэлгийн чиглэлээр 17 хүн ажиллаж байгаа ба 76.4% нь ЭСҮТөвдөө гистологи лаборантаар төрөлжсөн мэргэжил эзэмшсэн байна. ЭСҮТ-д эмгэг судлалаар 7 хүнийг ХБНГУ, БНСУ-ын ижил төстэй байгууллага болон сургуульд, 6 сараас 1 жилийн хугацаагаар, мөн ЭСҮТ-д 1.5 жилээр, гистологи лаборант 3 хүнийг ЭСҮТ-д 3 сараар мэргэжил эзэмшүүлэх хэрэгцээтэй гэсэн байна.

Ажиллах хүчний хувьд эмгэг судлаач 10 эмч, гистологи лаборант 3 орон тоо дутуу байна. Харин мэс заслын эмгэг судлал, хүүхэд эмэгтэйчүүдийн эмгэг судлалаар төрөлжсөн мэргэжил эзэмшсэн хүн байхгүй байна.

Тусламж, үйлчилгээ:

ЭСҮТ нь эдийн шинжилгээ, эсийн шинжилгээ, эмгэг судлалын задлан шинжилгээ, иммуногистохимийн шинжилгээ гэсэн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. 2013 оны байдлаар Үндэсний хэмжээнд гистологийн шинжилгээ 2368 хүнд (28341блок), амьд ахуй эдийн шинжилгээг мэс заслын болон онош тогтоох зорилгоор 52014 хүнд, цитологийн шинжилгээ 87395 удаа тус тус хийгдсэн байна. Задлан шинжилгээний хувь үндэсний хэмжээнд 77.8%-тай, үндсэн оношийн зөрөөний хувь 5.5%, хүндрэлийн зөрүүний хувь 5.9%-тай байна.

3.3.12. ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ (ЗӨСҮТ)**Хүний нөөцийн хангамж, чадавхи:**

Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь 2012 оны байдлаар удирдах ажилтан 3, статистикийн эмч 2, мэдээлэл технологийн мэргэжилтэн 3, их эмч 27, бусад дээд мэргэжилтэн 31, тусгай мэргэжлийн мэргэжилтэн 17, лаборант 9, бага эмч 5, бусад ажилтан 24, бүгд **104** ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 69. ЗӨСҮТ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН

	Эрдмийн болон мэргэжлийн зэрэг цол	Мэргэжилтний тоо		
		Их эмч	Бусад дээд мэргэжилтэн	Тусгай мэргэжилтэн
1	Шинжлэх ухааны доктор	1	-	-
2	Анагаах ухааны доктор	4	1	-
3	Магистр	6	7	-
4	Зөвлөх зэрэгтэй	3	-	-
5	Тэргүүлэх зэрэгтэй	6	-	1
6	Ахлах зэрэгтэй	4	1	2
7	Сурган заах арга зүйн эрх авсан, мэргэшсэн	-	-	-

ЗӨСҮТ-ийн их эмч, бусад дээд мэргэжилтний 32.7% нь эрдмийн болон боловсролын, 24.1% нь мэргэжлийн зэрэгтэй, тусгай мэргэжлийн 2 мэргэжилтэн ахлах зэрэгтэй байна. ЗӨСҮТ-ийн ажилчдын 72.1%-ыг эмэгтэйчүүд эзэлж байна.

ЗӨСҮТ-ийн нийт ажилчдын 72.4%-ыг эмэгтэйчүүд эзэлж, насны бүлгээр авч үзвэл 45.2% нь 20-39 насны залуучууд, 47.1% нь 40-54 насныхан эзэлж, их эмчийн 44.4% нь 20-39 насны залуучууд, 25.9% нь 40-49 насныхан, 18.5% нь 50-54 насныхан, 11.1% нь 55 ба түүнээс дээш насныхан эзэлж, их эмчийн 81.5% нь эмэгтэйчүүд байна.

ЗӨСҮТ нь Байгалийн голомтот халдварт өвчин судлалын чиглэлээр төрөлжсөн мэргэжил эзэмшүүлэх сургалтад 7 эмчийг сургаж, 1 эмчийг ХӨСҮТ-ийн талбарын тархвар судлаачаар мэргэшүүлсэн байна.

ХҮСНЭГТ 70. ЗӨСҮТ-ИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ХЭРЭГЦЭЭ

№	Төрөлжсөн мэргэшлийн нэр	хүний тоо	Хаана суралцах	
			Гадаад	Дотоод
1	“Байгалийн халдварт өвчин судлал” мэргэжлээр төрөлжсөн мэргэжил мэргэшүүлэх ариутгагчийн сургалт	10		ЗӨСҮТ
2	“Байгалийн халдварт өвчин судлал” мэргэжлээр төрөлжсөн мэргэжил мэргэшүүлэх лаборантын сургалт	10		ЗӨСҮТ
3	“Байгалийн халдварт өвчин судлал” мэргэжлээр төрөлжсөн мэргэжил мэргэшүүлэх биологчийн сургалт	10		ЗӨСҮТ
4	“Байгалийн халдварт өвчин судлал” мэргэжлээр төрөлжсөн мэргэжил мэргэшүүлэх эмчийн сургалт	10		ЗӨСҮТ
5	“Биоаюулгүй ажиллагаа: Зоонозын халдварын эпидемиологи ба микробиологи”-ийн чиглэлээр эмчийн мэргэжил эзэмшүүлэх сургалт	Тухайн шаардлага	Казахстаны улсын “Хөл хориот ба Зоонозын халдварын эрдэм шинжилгээний төв”	
6	“Биоаюулгүй ажиллагаа: Зоонозын халдварын эпидемиологи ба эпизоотологи”-ын чиглэлээр биологичийн мэргэжил эзэмшүүлэх сургалт	Тухайн шаардлага	Казахстаны улсын “Хөл хориот ба Зоонозын халдварын эрдэм шинжилгээний төв”-д	

ЗӨСҮТ нь Байгалийн халдварт өвчин судлал мэргэжлээр төрөлжсөн мэргэжил эзэмшүүлэх ариутгагч, лаборант, биологичиор 30 хүн, эмчээр 10 хүнийг шинээр өөрийн байгууллагадаа мэргэшүүлэх шаардлагатай гэсэн байна.

Харин биоаюулгүй ажиллагааны хүрээнд Зоонозын халдварын эпидемиологи ба микробиологи"-ийн чиглэлээр эмчийн мэргэжил эзэмшүүлэх сургалт, Зоонозын халдварын эпидемиологи ба эпизоотологи"-ын чиглэлээр биологичийн мэргэжил эзэмшүүлэх сургалтад Казахстан улсын “Хөл хориот ба Зоонозын халдварын эрдэм шинжилгээний төв”-д мэргэжилтнүүдээ сургах сонирхолтой байна.

Биостатистикч, мэдээлэл зүй, байгалийн голомтот халдварт өвчин судлалаар, лаборант, ариутгагч, нийт 6 орон тоо дутуу байна.

Тусламж, үйлчилгээ: ЗӨСҮТ нь байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний байгалийн голомтын тандалт судалгаа, хяналтыг хэрэгжүүлэн ажилладаг байна.

2012, 2013 оны байдлаар зоонозын хүний өвчлөлийн сэжигтэй дуудлага, хачгаар дамжих халдварт өвчний сэжигтэй дуудлагын тоо, өвчний ангилал бүрээр урд жилүүдээс нэмэгдсэн.,

Тухайлбал: тарваган тахлын хүний сэжигтэй дуудлага урд оноос 33.0%-иар, боомын хүний өвчлөлийн сэжигтэй дуудлага 12.0%, галзуу өвчний сэжигтэй амьтанд уруулсан дуудлага 1.8 дахин тус тус өссөн, мөн хачгаар дамжих халдварын тохиолдол сүүлийн 5 жилийн үзүүлэлтээс өсч, 146 бүртгэгдсэн ба тохиолдол бүрт хариу арга хэмжээ авч, хяналтын шинжилгээ, танадалт судалгаанууд хийсэн байна.

3.3.13. ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ (ЦССҮТ)

Хүний нөөцийн хангамж, чадавхи:

Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь 2012 оны байдлаар удирдах ажилтан 3, НЭМ-ийн мэргэжилтэн 1, мэдээлэл технологийн мэргэжилтэн 1, их эмч 9, бусад дээд мэргэжилтэн 7, тусгай мэргэжлийн мэргэжилтэн 26, лаборант 5, бага эмч 1, бусад ажилтан 10, бүгд 55 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 71. ЦССҮТ-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН

	Эрдмийн болон мэргэжлийн зэрэг цол	Мэргэжилтний тоо			
		Их эмч	Бусад дээд мэргэжилтэн	Сувилагч	Тусгай мэргэжилтэн
1	Шинжлэх ухааны доктор				
2	Анагаах ухааны доктор	1			
3	Магистр	3			
4	Зөвлөх зэрэгтэй	1			
5	Тэргүүлэх зэрэгтэй	2			1
6	Ахлах зэрэгтэй	1	1	8	2
7	Сурган заах арга зүйн эрх авсан, мэргэшсэн	3			

ЦССҮТ-ийн их эмч, бусад дээд мэргэжилтний 25.0% нь боловсролын, 31.2% нь мэргэжлийн, тусгай мэргэжлийн мэргэжилтний 42.3% нь мэргэжлийн зэрэгтэй байна. ЦССҮТ-ийн нийт ажилчдын 83.6%-ыг эмэгтэйчүүд эзэлж, насны бүлгээр авч үзвэл 61.8% нь 20-39 насны залуучууд, 34.5% нь 40-54 насныхан эзэлж, их эмчийн 55.5% нь 20-39 насны залуучууд, 44.5% нь 40-49 насныхан байна.

ХҮСНЭГТ 72. ЦССҮТ-ИЙН ЭМЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ

№	Төрөлжсөн мэргэжлээр мэргэшсэн байдал	Мэргэжилтний тоо	Хаана, ямар сургалтын байгууллагад суралцаж эзэмшсэн
1	Эрүүл мэндийн удирдлага судлал	1	Yiyueeei iaiaaadeei nodaaeo
2	Анагаах ухааны боловсрол судлал	1	YIJOEN-МДИ
3	Цусны өвчин судлал	1	OIOY
4	Үйлдвэрлэлийн цус сэлбэлт судлал	9	ONN- O
5	Арьс, гоо заслын	1	YIJOEN- МДИ
6	Aadeaa noaee	1	YIJOEN- МДИ
7	Цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологич	20	ONN- O

Байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамааран бүх эмч үйлдвэрлэлийн цус сэлбэлт судлал, цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн технологичиор өөрийн байгууллагадаа 3-6 сарын хугацаатай суралцан, төрөлжсөн мэргэжил эзэмшсэн байна.

ХҮСНЭГТ 73. ЦССҮТ-ИЙН -ИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ХЭРЭГЦЭЭ

№	Төрөлжсөн мэргэшлийн нэр	хүний тоо	Хаана суралцах	
			Гадаад	Дотоод
1	Eiioifaaiaaioieiaae- yi-	2		
2	OOA zeeaaudeyeeei daoifiaae- oonaae iudayueeoyi	5		
3	Odaiooocoeieiaae- eo yi-	2	ajao	
4	Ooniuaaaiiu aedoniieiaae- eo yi-	2	oaaeeoye	
5	OOA zeeaaudeyeeei daoifiaae- eo yi-	2	ioiu ooniua	
6	Bedon eayaaazeeezeyo daoifiaae	2	aaaiia	
7	Aiioo cioei aaeaooeaee	2		
8	Ooniuaaaiiu oiiia ooooiiaeeei eiaaiad	2		YIJOEN
9	Ydzze iyiaeei daedaaana noaee	5		YIJOEN
10	Ozlee iooeei iaiaaadeei nodaaeo	1		YIJOEN
11	Ydzze iyiaeei noadenee	1		YIJOEN, ЭМХТ
12	leeaieei ydzze iyia noaee	1		YIJOEN
13	Badaeoaee oonaae noaee	1		YIJOEN
14	Ydhaeeei daedaaana	1		YIJOEN
15	Aedoniieiaae, aaeoadeieiaae, naoieiaae /eaaioaio/	1		YIJOEN
16	Oaeeaaad oaiiaaeeae, eaaioaioieei aroeeze aaeaae	1		YIJOEN
17	Eaaiiaio	4		YIJOEN

ЦССҮ төв нь дэвшилтэт технологийн нэвтрэлттэй уялдан үйл ажиллагааны онцлог руу чиглэсэн 8 үндсэн чиглэлийн хүрээнд 19 мэргэжилтэнг өндөр хөгжилтэй орны ижил үйлчилгээтэй байгууллагын туршлагаас суралцах, мэргэжил дээшлүүлэх чиглэлээр, 16 мэргэжилтэнг 9 чиглэлийн хүрээнд ЭМШУИС болон сургалт эрхлэгч бусад байгууллагууд суралцуулах сонирхолтой байна.

2013 ий 11-р нăдă ÕÑÑ- Õ-èéí áçòyò äçðyí øeíy+ëyi áàðeääāñāíðae õíeāññíðíeāññ òðāíñòóçeíeíāe+ èò ýì±, ±āóñíeíāe± èò ýì±, ±āíāðūí íāíāæāð, ñeéāìèéí ýðççè ýííāèéí ýððāyæèèèðyí, ñýðāyè ççé±, ðāíāðāðíðèéí ýì±, лаборант, òññā ò°ð°ð°íæèéí eíæāíāð зэрэг 18 íðíí òññ āòòóò àæèèèèæ àáéíā.

2014 ийд õòñ òóāeóóèāð ñóóðeí õyā áàeāóóèāí àæèèèèāòāð ò°è°āe°æ àáéāāā, 2015 ийд ÕÑÑ- Õ-èéí øeíy áàeð àðeāèeðāíā íðæ, çèè àæèèèèāāāā òðā°æìхтэй õíeāññíðíeāññ øeíyýð 95 íðíí òññ ýíeæ шаардлагатай байна.

Тусламж, үйлчилгээ: 2013 оны байдлаар нийт 22813 донор байгаа ба 9050.97 литр цус, сийвэн цуглуулсанаас 89.8% нь үйлдвэрт тэнцсэн бүтээгдэхүүн нийлүүлсэн байна. Цуглуулсан цус, сийвэнгийн нэгж бүрд цусны бүлэг тодорхойлох, халдвар илрүүлэх шинжилгээг 22639 донорт хийсэн ба 89.5% нь тэнцэж, 10.5% нь өвчин илэрсэн байна. 2013 онд 10005.83 литр цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 94.6% нь эмнэлэгт олгогдсон байна.

Цус, цусан бүтээгдэхүүний чанарын шинжилгээгээр арчдасны шинжилгээг 3342 удаа хийсний шаардлага хангасан хувь 98.8%, агаарын шинжилгээг 523 удаа хийсний шаардлага хангасан хувь 98.8%, цус, цусан бүтээгдэхүүний ариун чанарын шинжилгээ 4285 удаа, шаардлага хангасан хувь 99.0%-тай байна.

ЦССҮТ нь вирус идэвхигүйжүүлэх, сийвэнгийн бүтээгдэхүүний хорионы технологи, судас хатгахын өмнөх өвчин намдалт, лазер өндөг цоологч, цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, захиалга, борлуулалт, нөөцийн үйл ажиллагааны цахимжилт, лабораторын технологийн шинэчлэлийг хийж, утгах үйлчилгээний соёл, тав тухтай байдлыг хангаж ажилласан байна.

3.3.14. ХҮҮХДИЙН ТӨВ СУВИЛАЛ (ХТС)

Хүний нөөцийн хангамж, чадавхи:

Хүүхдийн төв сувилал нь 2012 оны байдлаар удирдах ажилтан 3, статистикч эмч 1, мэдээлэл технологийн мэргэжилтэн 1, ХШҮ хариуцсан мэргэжилтэн 1, их эмч 13, эм зүйч 1, бусад дээд мэргэжилтэн 5, тусгай мэргэжлийн мэргэжилтэн 41, үүнээс сувилагч 39, лаборант 1, эм найруулагч 1, бусад ажилтан 43, бүгд **109** ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 74. ХТС-ИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ АЖИЛЛАХ ХҮЧИН

	Эрдмийн болон мэргэжлийн зэрэг цол	Мэргэжилтний тоо			
		Их эмч	Бусад дээд мэргэжилтэн	Сувилагч	Тусгай мэргэжилтэн
1	Шинжлэх ухааны доктор	-	-	-	-
2	Анагаах ухааны доктор	-	-	-	-
3	Магистр	5	1	-	-
4	Зөвлөх зэрэгтэй	-	-	1	-
5	Тэргүүлэх зэрэгтэй	2	-	15	-
6	Ахлах зэрэгтэй	-	-	-	-
7	Сурган заах арга зүйн эрх авсан, мэргэшсэн	-	-	-	-

ХТС-ийн их эмч, бусад дээд мэргэжилтний 33.3% нь магистр, их эмчийн 15.4% нь тэргүүлэх, сувилагчийн мэргэжилтний 41.0% нь зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй байна.

ХТС-ын нийт ажилчдын 94.5%-ыг эмэгтэйчүүд эзэлж, насны бүлгээр авч үзвэл 36.7% нь 20-39 насны залуучууд, 63.3% нь 40-54 насныхан эзэлж, их эмчийн 46.1% нь 20-39 насны залуучууд, 30.7% нь 40-49 насныхан байна.

Ажилласан жилийн туршлагаас харахад нийт ажилтны 26.6% нь 10 хүртэл жил, 22.9% нь 11-20 жил, 41.3% нь 21-29, 26.6% нь 30 ба түүнээс дээш жил ажилласан байна.

ХҮСНЭГТ 75. ХТС-ИЙН ЭМЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛЭЭР МЭРГЭШСЭН БАЙДАЛ

№	Төрөлжсөн мэргэжлээр мэргэшсэн байдал	Мэргэжилтний тоо	Хаана, ямар сургалтын байгууллагад суралцаж эзэмшсэн
Хүүхдийн өвчин судлал			
1	Нярай судлал	4	ЭМШУИС-ийн МДИ, ЭХЭМҮТ
2	Хүүхдийн эмчийн	1	ЭМШУИС-ийн МДИ
3	Хүүхдийн бөөрний өвчин судлал	1	ЭМШУИС-ийн МДИ
Сэргээн засах анагаах ухааны судлал			
4	Хүүхдийн сэргээн засал судлал	2	Оргил рашаан сувилал, БНСУ
Эм зүй судлал			
5	Эмнэлзүйн эм зүй судлал	1	ЭМШУИС-н МДИ-д
Сувилахуй			
6	Хүүхдийн сувилахуй	1	ЭХЭМҮТөв
7	Нярайн сувилахуй	6	ЭМШУИС, ЭХЭМҮТ
8	Сэргээн засах эмчилгээний	1	Оргил рашаан сувилал
9	Бариа заслын	3	ЭМШУИС
10	Яаралтай тусламжийн	1	Сингапурт
Тусгай мэргэжилтэн			
11	Эрүүл мэндийн статистикч	1	ЭМХТөв

Их эмчийн 46.2% нь хүүхдийн өвчин судлалын чиглэлээр, 15.4% нь хүүхдийн сэргээн засах чиглэлээр ЭМШУИС болон ЭХЭМҮТ-д мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад суралцан, нярай судлал, хүүхдийн бөөрний өвчин судлал, сэргээн засах чиглэлээр мэргэшсэн байна. Мөн хүүхэд, нярайн сувилахуй, бариа засал, сэргээн засах, яаралтай тусламжийн чиглэлээр нийт сувилагчийн 30.8% нь мэргэшсэн байна. Дэвшилтэт технологитой уялдан шинээр мэргэшүүлэх сургалтын хэрэгцээ өнөөгийн байдлаар бага байна. Харин туслах сувилагч 6 шаардлагатай байна.

Тусламж, үйлчилгээ: 2012 оны байдлаар 90 ор ажиллан, 278 хүүхэд сувилгаа, эмчилгээ хийлгэсэн байна. Нийт ор хоног 2519 байна. Мөн онд давхардсан дүнгээр уламжлалт анагаах ухаан заслын эмчилгээг 906 хүүхдэд хийсний 30.5% нь бүтэн биеийн бариа, 43.3% нь жин засал, 8.8% нь төөнө эмчилгээ эзэлж байна. Сэргээн засах эмчилгээг 1199 удаа хийсний 47.8% нь усан эмчилгээ, 37.5% нь цахилгаан эмчилгээ байна.

Лабораторын 3743 шинжилгээ хийсний 31.4% нь гематологийн, 58.6% нь клиникийн химийн, 9.9% нь микробиологийн шинжилгээнүүд эзэлж байна. Мөн ХТС нь биохимийн лабораторыг шинээр зохион байгуулан, тусламж, үйлчилгээний чанар, халдвар хамгааллын дэглэмийн талаар цөөнгүй шинэлэг ажил хийдэг байна.

Товч дүгнэлт: ЭМЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд 5415 эрүүл мэндийн ажиллах хүчин ажиллаж байгаагийн 21.5% нь их эмч, 33.2% нь сувилагч мэргэжилтэн байна. Хүйсээр авч үзвэл дунджаар 19.3% нь эрэгтэйчүүд, 80.7% нь эмэгтэйчүүд байна. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд 1162 их эмч ажиллаж байгаагийн эхний 5 байранд 9.3%-иар дотрын эмч, 9.0%-иар мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний эмч, 8.7%-иар мэс заслын эмч, 8.1%-иар лабораторын их эмч, 6.8%-иар хүүхдийн эмч тус тус орж байна.

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд ШУ-ны болон анагаах ухааны доктор 90, магистр 281, мэргэжлийн зэрэгтэй 613 их эмч, сувилагч 620 байгаа ба энэ нь нийт ажиллах хүчний 29.6%-ийг эзэлж байна. ШУ-ны болон боловсрол, мэргэжлийн зэрэгтэй ажиллах хүчний хувьд УГТЭ, ЭХЭМҮТ, ХСҮТ манлайлагч байна.

Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвүүдийн гаргаж өгсөн судалгаагаар сурган заах арга зүйгээр мэргэшсэн 168 мэргэжилтэн байгаагийн 42.3% нь ЭХЭМҮТ-д, 23.8% нь ГССҮТ-д, 15.5% нь УНТЭ-т ажиллаж байна. Гэтэл халдварт өвчин судлалаар үндэсний хэмжээнд сургалт явуулдаг ХӨСҮТ болон УГТЭ-т сурган заах арга зүйгээр мэргэшсэн хүн байхгүй байна.

Лавлагаа төвүүдэд дэвшилтэт технологитой уялдан 346 их эмч, бусад дээд мэргэжилтэн, 699 сувилагч, бусад тусгай мэргэжлийн мэргэжилтэн, бүгд 1045 хүнийг өндөр хөгжилтэй орнуудад болон эх орондоо шинээр мэргэшүүлэх хэрэгцээтэй байна. Ялангуяа сувилагч, тусгай мэргэжлийн мэргэжилтэнг төрөлжсөн мэргэжлээр мэргэшүүлэх хэрэгцээ өндөр байна.

Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын ачаалал, шинээр нэвтэрч буй стандарттай холбоотойгоор 304 их эмч, 723 тусгай мэргэжлийн мэргэжилтэн шаардлагатай гэсэн ба дийлэнх нь сувилагч мэргэжил байна. ЭХЭМҮТ-өөс бусад тусгай мэргэжлийн төвүүд болон төв эмнэлгүүдийн сурган заах арга зүйн эрх авсан эмч, мэргэжилтний тоо харьцангуй цөөн байна. Лавлагаа төвүүдийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт хангалтгүй, сургалтын зорилго, зорилт хэрэгцээ тодорхой бус байна.

ХЭЛЦЭМЖ

Өнөөгийн байдлаар Монгол улсын 2.867.744 дундаж хүн амд 2925 эрүүл мэндийн байгууллагын 43626 эрүүл мэндийн ажиллах хүчин үйлчилж байна. Үүний 42103 нь эрүүл мэндийн салбарт ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагуудад 8597 их эмч, 16871 тусгай мэргэжлийн мэргэжилтэн, үүнээс 9916 сувилагч ажиллаж байна.

2009-2012 оны 4 жилийн динамикаар эрүүл мэндийн ажиллах хүчний хүйсийн бүтэц онцын өөрчлөлтгүй, эрүүл мэндийн нийт ажиллах хүчний 82.3%, их эмчийн 79.1%-ийг эмэгтэйчүүд эзэлж, 7300 орчим эрэгтэйчүүд ажиллаж байгаагийн 22.3% буюу 1630 нь эрэгтэй их эмч байна. Харин 2012 онд хүйсийн бүтэцэд бага зэрэг өөрчлөлт гарч, эрэгтэй ажиллах хүчин урд оноос 0.7%-иар өссөн байна.

Эрүүл мэндийн ажиллах хүчний дийлэнхийг 30-49 насныхан (57.8%) эзэлж байгаа хэдий ч жил тутам буурсан, 20-29 насны (22.5%) залуу ажиллах хүчин жил тутам нэмэгдсэн хандлага ажиглагдаж байна.

Эрүүл мэндийн байгууллагын тоо 4 жилийн динамикаар, жилд дунджаар 106-аар, 2011, 2012 онд өсөлт хамгийн өндөр буюу 270-аар нэмэгдсэн байна. Байгууллагын тооны өсөлтөд рашаан сувилал, хувийн үүдэн эмнэлэг, эмийн сангийн өсөлт голлох байр суурийг эзэлж байна. Гэхдээ үүдэн эмнэлгийн тоо буурах хандлагатай байна.

Эрүүл мэндийн ажиллах хүчний тоо жил тутам өссөн, суурь онтой (2009) харьцуулахад рашаан сувилалд 2.1 дахин, хувийн үүдэн эмнэлэгт 1.3 дахин, эмийн санд 1.2 дахин ажиллах хүчин нэмэгдсэн, гуравдагч шатлалд 1.1 дахин, анхдагч, хоёрдогч шатлалд 1.0 дахин өссөн байна.

Эрүүл мэндийн ажиллах хүчний хангамжийг авч үзвэл 2012 оны байдлаар эрүүл мэндийн ажиллах хүчний 19.7% нь их эмч, 39.8% нь тусгай мэргэжлийн мэргэжилтэн, 28.2% нь бусад ажилтан, 12.3% нь бусад мэргэжилтэн байна.

Мөн нийт ажиллах хүчний 1.8% нь удирдах ажилтан, 1.2% нь нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, 0.2% нь статистикч, 0.3% нь мэдээллийн технологийн мэргэжилтэн, 0.1% нь хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, 0.1% нь хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, 0.2% нь мэргэжлийн хяналтын албаны улсын байцаагч, 3.4% нь эм зүйч, 4.9% нь бусад мэргэжилтэн эзэлж байна.

Их эмчийн байршил, хангамжийг 34 мэргэжлээр авч үзвэл 2012 оны байдлаар эхний 5 байранд 11.2%-иар өрх, сумын, 9.8%-иар дотрын, мөн хувиар ерөнхий мэргэжлийн, 7.8%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 6.7%-иар хүүхдийн эмч орж байна. Аймгуудын хувьд эхний 5 байранд 18.5%-иар ерөнхий мэргэжлийн, 13.8%-иар өрх, сумын, 9.3%-иар дотрын, 8.2%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 7.9%-иар хүүхдийн эмч орж байна. Улаанбаатар хотын хувьд эхний 5 байранд 10.5%-иар шүдний, 10.2%-иар дотрын, 9.7%-иар өрхийн, 7.6%-иар эх барих, эмэгтэйчүүдийн, 6.1%-иар уламжлалт анагаахын эмч орж байна.

Өрх, сумын эмч, ерөнхий мэргэжлийн эмч гэсэн ангилалд аймаг бүр хэт зөрөөтэй, мэдээлэл өгдөг, тухайлбал: Төв аймагт өрх сумын эмч 3, Өвөрхангай аймагт 58, ижил утгаар, Завхан аймаг ерөнхий мэргэжлийн эмч 52 байхад, Булган аймагт 2 байх жишээтэй байна.

2012 оны эрүүл мэндийн үзүүлэлтээр Монгол улсад 10000 хүнд **30.3** их эмч ногдож байгаа нь хөгжиж байгаа орнуудаас 3 дахин, хөгжингүй орнуудаас 1.4 дахин, өндөр хөгжилтэй орнуудаас 0.9 дахин, дэлхийн болон олон улсын дунджаас 2.1 дахин өндөр байна. Мөн аймагт **21.1**, Улаанбаатар хотод **41.1** их эмч ногдож байгаа нь дэлхийн болон олон улсын дунджаас өндөр байна.

Сувилагч, эх баригч мэргэжлийн хувьд өндөр хөгжилтэй орнуудаас 2.1 дахин бага, олон улс, дэлхийн дунджаас 1.1 дахин өндөр, шүдний эмч хөгжиж байгаа орнуудаас 2.8 дахин өндөр, өндөр хөгжилтэй орнуудаас 3.5 дахин, дэлхийн дунджаас 1.6 дахин бага, эм зүйч олон улс, дэлхийн дунджаас 1.6 дахин өндөр, НЭМ-ийн ажилтан олон улс, дэлхийн дунджаас 1.5 дахин бага байна.

Хүн ам өсөхийн хэрээр эрүүл мэндийн ажиллах хүчний тоо өсч, 4 жилийн дунджаар хүн ам 1.6%-иар өсч байхад эрүүл мэндийн ажиллах хүчин 3.6%-иар өссөн байна.

Аймгуудын эрүүл мэндийн ажиллах хүчний өсөлт нь хүн амын өсөлт, бууралттай харилцан хамаарал багатай, цөөхөн хүн амтай аймгуудад олон хүн амтай аймгуудаас ажиллах хүчний тоогоор илүү, хүн амын шилжилт, хөдөлгөөн их байсан ч орон тоо буураагүй, байнга нэмэгдэж байсан байна.

10000 хүнд ногдох эрүүл мэндийн ажилтны улсын дундаж 153.6, аймгийн дундаж 138.1 байгаа ба дунджаар 101.392 хүн амтай Сэлэнгэ аймагт 107.5 байгаа нь хамгийн бага, 53335 хүн амтай Говь-Алтай аймагт 196.1 хүн ногдож байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна.

Мөн 50000-аас дотогш хүн амтай аймгуудад 10000 хүнд 147.4-196.1 эрүүл мэндийн ажилтан ногдож байхад 90.000 дээш хүн амтай аймгуудад 10000 хүнд 107.5-133.2 ажилтан ногдож байна. 1.302.615 хүн амтай Улаанбаатар хотын 10000 хүнд 172.0 эрүүл мэндийн ажилтан ногдож байгаа ба энэ нь аймаг, улсын дунджаас дээгүүр байна.

Эрүүл мэндийн байгууллагууд нь эрдмийн болон мэргэжлийн зэрэг цолтой хүмүүсээ буруу мэдээлдэг, мэдээлэлд дүн шинжилгээ хийдэггүйгээс мэргэжлийн зэргийн хөгжлийг динамикаар харах боломжгүй болгож байна.

ЭМЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд 5415 эрүүл мэндийн ажиллах хүчин ажиллаж байгаагийн дийлэнх нь эмэгтэйчүүд эзэлж байна. Тэдний 29.6%-нь эрдмийн болон боловсрол, мэргэжлийн зэрэгтэй ажиллах хүчин байна.

Лавлагаа төвүүдэд дэвшилтэт технологитой уялдан 1045 хүнийг өндөр хөгжилтэй орнуудад болон эх орондоо шинээр мэргэшүүлэх, 1027 хүн шинээр ажилд авах хэрэгцээтэй байна. Шинээр мэргэшүүлэх болон ажилд авах шаардлагатай мэргэжлийн дийлэнх нь сувилагч мэргэжил байна.

Гадаадын улс орнуудаас тухайлбал: БНСУ, Тайвань, АНУ, Франц, Япон, ХБНГУ, ОХУ, Сингапур, Энэтхэг, Австрали, Казакстан зэрэг улс орнуудад төрөлжсөн мэргэжлийн онцлогоос хамааран 3-6 сарын хугацаатай суралцан мэргэжил дээшлүүлэхийг чухалчилж байна.

Эрүүл мэндийн дэвшилтэт технологийн нэвтрэлт болон үйл ажиллагааны өргөжилттэй холбоотойгоор ахуй засалч, хэл ярианы гажиг засалч, хөдөлгөөн засалч, сэтгэл зүйч болон эмнэлгийн өндөр технологийн тоног төхөөрөмжийн инженер, техникийн ажилтан зэрэг мэргэжлийн ажиллах хүчнээр хангах хэрэгцээ хөдөө орон нутагт болон лавлагаа төвүүдэд шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Эрүүл мэндийн салбарт дийлэнх нь эмэгтэйчүүд ажиллаж, насны хувьд жил ирэх тутам залуужих хандлага ажиглагдаж байна.

Хүн амын 54.1% хөдөө орон нутагт амьдарч, эрүүл мэндийн нийт ажиллах хүчний 48.6%, их эмчийн 37.7%, сувилагчийн 49.5% нь хөдөө аймагт байршиж байна. Улаанбаатар хотод хүн амын 45.9% нь амьдарч, ажиллах хүчний 51.4%, их эмчийн 62.3%, сувилагчийн 50.5% нь байршиж байна.

Эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний өсөлт жил тутам нэмэгдсэн ба өсөлтөд хүн амын өсөлт, бууралт, шилжилт хөдөлгөөн харилцан хамаарал багатай, өөрөөр хэлбэл аймгуудын хүн амын тоо буурсаар байхад, ажиллах хүчний тоо нэмэгдсээр байна. Энэ нь 10000 хүн амд ногдох их эмчийн тоо харилцан адилгүй, хэлбэлзэл ихтэй байхад шууд нөлөөлж байна.

Монгол улс 10000 хүнд ногдох их эмчийн тоогоороо дэлхийн болон олон улсын дунджаас 2.1 дахин, сувилагч эх баригч 1.1 дахин өндөр байна. Харин шүдний эмч 0.8 дахин, нийгмийн эрүүл мэндийн ажилтан 1.5 дахин бага байгаа бол эм зүйч 1.6 дахин өндөр байна.

ЭМЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд 5415 эрүүл мэндийн ажиллах хүчин ажиллаж байгаагийн 29.6%-нь эрдмийн болон боловсрол, мэргэжлийн зэрэгтэй ажиллах хүчин байна. Нийт ажиллах хүчний 19.3%-ыг шинээр мэргэшүүлэх, 18.9%-иар нэмэгдүүлэх хэрэгцээтэй гэж үзсэн байна.

Эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлтэд өнөөг хүртэл хилийн цэрэг, төмөр замын эмнэлэг, хорихын эмнэлгүүд, сургууль, ясли, цэцэрлэг, уурхай, мэргэжлийн хяналтын газар зэрэг өөр салбарын байгууллага, тэнд ажиллаж байгаа хүний нөөцийн үзүүлэлтийг бүртгэгдэж, салбарын тоо мэтээр мэдээлэгдэж ирсэн байна.

Эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр хүний нөөцийн хөгжлийн нэг үзүүлэлт болох эрдмийн болон мэргэжлийн зэрэг цолтой эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны динамикийг гаргах, дүн шинжилгээ хийх боломжгүй, бодит тоо буруу байна.

Эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр эрүүл мэндийн байгууллагын хүний их эмчийг ажлын байрны нэрээр 34 ангилан үзүүлэлт гаргадаг. Энэ үзүүлэлтэд өрх, сумын эмч, ерөнхий

мэргэжлийн эмч гэсэн ангилалд энэ чиглэлээр ажиллаж байгаа эмчийн тоо аймаг бүрт хэт зөрөөтэй.,

Жишээлбэл: 2012 оны байдлаар Төв, Увс, Завхан, Сүхбаатар аймагт өрх, сумын эмч нь 3-5 хүн, ерөнхий мэргэжлийн эмч нь 25-52 байгаа бол Баянхонгор, Дорнод, Өвөрхангай, Говь-Алтай аймагуудад өрх, сумын эмч 47-58 хүн, ерөнхий мэргэжлийн эмч 2-10 хүн байх жишээтэй байна. Энэ нь 2001 онд ЭМСХХ-ийн хүрээнд анх удаа өрхийн эмчийн 6 сарын эмнэл зүйн сургалт хийж, өрхийн эмчийн мэргэжлийн үнэмлэх олгосонтой нэг талаараа холбоотой байна. Гэсэн хэдий ч энэ нь ерөнхий мэргэжлийн эмч гэсэн нэршилтэй холигдож, зарим аймаг сум, өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаа эмч нараа ерөнхий эмч гэсэн нэршлээр, зарим аймаг өрх сумын эмч гэсэн нэршлээр нэрлэж байгаа нь оновчгүй байна.

Лавлагаа төвүүдэд дэвшилтэт технологитой уялдан мянга гаруй хүнийг БНСУ, Тайвань, АНУ, Франц, Япон, ХБНГУ, ОХУ, Сингапур, Энэтхэг, Австрали, Казакстан зэрэг улс орнуудад болон өөрийн орондоо төрөлжсөн мэргэжлийн онцлогоос хамааран 3-6 сарын хугацаатай суралцан мэргэжил дээшлүүлэхийг чухалчилж байна. Шинээр мэргэшүүлэх мэргэжлийн дийлэнх нь сувилагч мэргэжил байна.

ЗӨВЛӨМЖ

Монгол улсын хүн ам, 10000 хүнд ногдох үзүүлэлтэд тулгуурлан, хүн ам тасралтгүй буурсаар байгаа аймгуудын ажиллах хүчний тоог цөөрүүлэх, өсөж байгаа аймгуудын ажиллах хүчний тоог нэмэгдүүлэх зэргээр зохион байгуулалтын шинэчлэл хийх замаар эрүүл мэндийн салбарын ажиллах хүчний байршил, хангамжийг оновчтой болгох

Их эмчийн тооны харьцаа дэлхийн болон олон улсын дунджаас байнга өндөр, ялангуяа Улаанбаатар хотод хэт өндөр байгааг бодлогын түвшинд анхаарч, их эмчийн тоог нэмнэ гэхээсээ тэдний үзүүлж буй тусламж, үйлчилгээний чанартай хэрхэн уялдуулах талаар судлан, арга хэмжээ авч хэрэгжүүлэх

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг ажиллах хүчний тоог нэмэгдүүлэх, шинэ технологи, үйл ажиллагааны өргөжилттэй холбоотойгоор ахуй засалч, хэл ярианы гажиг засалч, хөдөлгөөн засалч, сэтгэл зүйч болон өндөр технологийн тоног төхөөрөмжийн инженер, техникийн ажилтан зэргийг бэлтгэх, хөдөө орон нутагт ажиллахыг бодлогоор дэмжих

Эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлтэд бүртгэгдсэн өөр салбарын хүний нөөцийн үзүүлэлтийг бүртгэгдэх шаардлагатай гэж үзвэл тусад нь ангилан авч үзэх, гэхдээ одоо байгаа мэдээлэл нь бүрэн биш, дунджаар 1800 орчим хүний мэдээлэл байгааг анхааралдаа авч, мэдээллийг бүрэн авч, дүн шинжилгээ хийх боломж бүрдүүлэх

Эрүүл мэндийн статистик үзүүлэлтийн эрүүл мэндийн салбарын ажиллах хүчин, хүний нөөцтэй холбоотой бүртгэл, мэдээллийг чанарыг сайжруулах, ялангуяа удирдах ажилтан, өрх, сумын эмч, ерөнхий мэргэжлийн эмч гэдэгт хэнийг бүртгэх талаар тодорхой зааварчилгаа өгч, зөв мэдээлэлтэй болох

ЭМЯ-ны харьяа байгууллагууд хүний нөөцийн хөгжлийн бодлогыг байгууллагын хөгжлийн стратегид тулгуурлан оновчтой боловсруулах

Лавлагаа төвүүдийн шинээр мэргэшүүлэх хэрэгцээг бодлогын түвшинд анхаарч зөв бодлогоор, өөрөөр хэлбэл тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжтэй уялдуулан дэмжих

ЭМХТ нь БНСУ, Тайвань, АНУ, Франц, Япон, ХБНГУ, ОХУ, Сингапур, Энэтхэг, Австрали, Казакстан болон бусад улс орнуудтай төгсөлтийн дараах сургалтын хамтын ажиллагааг өргөжүүлэх, чанаржуулах талаар бодлого боловсруулан хэрэгжүүлэх

Эрүүл мэндийн дэвшилтэт технологийн нэвртэлт болон үйл ажиллагааны өргөжилттэй холбоотойгоор шинээр гарч ирж буй мэргэшлүүдээр (эрүүл мэндийн сэтгүүл зүй, эрэгтэйчүүдийн өвчин судлал, ахуй засал, хэл засал судлал, хөдөлгөөн засал, сэтгэл зүйч, үений дурангийн мэс засал зэрэг) мэргэжлийн ажиллах хүчнийг мэргэшүүлэх, хангахад эрүүл мэндийн байгууллагууд анхаарч ажиллах

ХАВСРАЛТ 1.

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ БАЙРШИЛ, ХАНГАМЖ-АЙМГААР

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн ам
2009	Архангай	4	16	125	33	259	148	4	33	40	392	1054	92477
2010		5	17	136	49	255	163	4	33	50	406	1119	92041
2011		4	21	143	55	254	165	4	34	49	411	1141	84478
2012		4	16	147	57	262	163	4	34	52	408	1143	84765
2009	Баян-өлгий	3	12	132	36	247	146	6	26	37	363	1008	101569
2010		14	13	144	45	251	143	7	32	37	361	1047	101342
2011		7	12	145	48	243	146	7	31	50	355	1048	88478
2012		8	13	145	44	245	170	7	32	40	354	1061	89642
2009	Баян-хонгор	6	16	104	49	246	153	5	19	42	391	1031	85271
2010		7	18	111	59	248	147	5	21	65	346	1027	85249
2011		7	23	125	63	253	162	5	20	51	368	1077	76436
2012		6	22	134	70	273	167	5	28	60	364	1129	77249
2009	Булган	5	18	94	33	186	124	4	12	20	288	784	61883
2010		10	15	91	38	186	129	2	17	28	263	774	58863
2011		15	22	101	35	196	125	1	15	27	258	785	53909
2012		16	23	108	34	198	121	2	17	31	262	801	54333
2009	Говь-Алтай	8	12	115	68	223	160	6	32	42	333	999	59599
2010		7	11	124	72	223	180	5	32	41	332	1027	58863
2011		5	14	138	75	227	177	5	32	41	322	1036	53259
2012		5	17	149	75	229	178	6	33	37	317	1046	53334
2009	Говьсүмбэр	2	6	41	9	53	33	1	6	9	60	220	13085
2010		5	8	39	10	52	30	2	6	13	61	226	13533
2011		4	10	45	9	53	29	2	6	16	61	235	13591
2012		2	8	48	9	58	31	2	6	14	61	239	14084
2009	Дархан	2	9	231	57	327	101	9	29	69	324	1158	89118
2010		3	10	231	61	327	91	9	31	71	314	1148	90889
2011		5	12	242	76	337	105	9	32	83	319	1222	95477
2012		4	13	248	85	355	109	10	30	94	340	1292	96974
2009	Дорноговь	6	16	178	55	174	93	3	15	41	239	820	57788
2010		9	17	184	51	185	88	3	13	49	257	856	58929
2011		11	22	179	59	179	91	3	10	52	262	868	59533
2012		15	27	183	85	178	90	5	11	60	271	925	60754
2009	Дорнод	6	18	138	28	227	106	7	25	32	367	954	73604
2010		7	25	134	29	231	104	7	20	38	353	948	73621
2011		7	27	138	23	241	98	8	21	53	340	956	69983
2012		8	27	159	26	243	102	7	21	54	360	1007	70745
2009	Дундговь	3	13	91	23	147	107	3	19	26	235	667	47952
2010		4	11	88	26	148	103	2	18	24	235	659	46993
2011		3	13	84	26	138	102	2	18	22	225	633	38227
2012		3	18	99	29	144	106	3	17	33	238	690	37750
2009	Завхан	5	9	118	58	247	189	3	28	37	388	1082	79565
2010		5	11	120	64	222	203	4	29	41	386	1085	78091
2011		4	18	128	64	224	200	5	31	63	358	1095	64796
2012		4	18	143	68	242	177	6	31	62	385	1136	64422
2009	Орхон	5	22	224	51	321	67	14	27	55	218	1004	82543
2010		5	32	246	93	327	86	15	27	72	262	1165	84444
2011		3	32	252	78	315	120	15	27	66	243	1151	91218
2012		4	33	257	105	327	122	15	29	79	264	1236	92159
2009	Өвөрхангай	9	13	173	51	277	174	4	23	48	416	1188	117040
2010		8	17	176	61	288	187	4	24	59	399	1223	117461
2011		7	20	180	65	285	183	6	23	75	391	1235	101293
2012		4	20	194	75	292	186	7	25	88	363	1254	101686
2009	Өмнөговь	7	12	106	38	125	103	5	14	28	166	604	48517
2010		5	16	117	45	123	11	8	15	30	159	629	50173
2011		4	26	119	43	138	102	10	19	32	171	664	62509
2012		4	20	135	42	157	107	7	17	38	173	700	64400

Он	Аймаг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	Шүд, гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Хүн амын тоо
2009	Сүхбаатар	8	17	101	36	167	100	2	19	31	268	749	54942
2010		6	17	106	41	160	114	2	20	33	264	763	54988
2011		5	20	112	41	157	112	5	20	36	260	768	61602
2012		8	18	115	43	166	116	5	19	36	257	783	52214
2009	Сэлэнгэ	11	24	165	48	280	140	6	32	57	350	1113	102509
2010		9	31	161	49	277	154	6	33	63	348	1131	104992
2011		8	13	166	46	262	151	6	36	55	343	1086	98558
2012		6	18	160	50	263	155	4	31	54	349	1090	101392
2009	Төв	4	20	131	55	235	136	4	27	32	408	1052	87639
2010		4	24	138	60	233	140	4	28	35	394	1060	89364
2011		6	30	154	78	243	144	3	27	49	400	1134	85558
2012		6	35	159	97	253	137	3	29	45	404	1168	86262
2009	Увс	12	16	116	42	242	172	4	26	33	303	966	79299
2010		7	18	122	47	244	155	3	25	53	304	978	78504
2011		7	22	120	45	241	160	3	24	64	296	982	73106
2012		6	22	136	50	231	155	3	29	93	291	1016	73404
2009	Ховд	7	12	123	45	251	154	7	31	39	299	968	88448
2010		7	17	148	41	248	171	11	33	33	293	1002	88454
2011		5	20	149	61	233	197	10	33	48	245	1001	77023
2012		5	19	169	64	232	201	10	33	52	272	1057	77785
2009	Хөвсгөл	6	21	160	49	322	240	6	40	79	447	1370	123572
2010		3	22	175	53	334	225	6	41	88	445	1392	124348
2011		8	23	172	57	305	261	5	40	89	421	1395	115437
2012		9	21	198	66	331	262	8	39	89	431	1469	116790
2009	Хэнтий	3	15	146	51	221	125	5	21	33	343	963	71232
2010		3	17	141	50	221	130	3	17	37	347	966	71603
2011		4	21	144	51	225	125	3	20	45	330	968	66195
2012		6	23	152	44	234	126	3	18	46	333	985	66957
2009	Нийт аймаг	122	317	2812	915	4777	2771	108	504	830	6598	19754	1617649
2010		128	368	2932	1044	4783	2854	112	515	960	6529	20225	1626366
2011		119	428	3036	1094	4749	2955	117	519	1084	6379	20480	1520547
2012		122	439	3238	1211	4913	2981	123	529	1174	6497	21227	1537096
2009	УБ	649	179	4328	1795	4240	424	232	375	1528	5200	18950	1092003
2010		488	257	4565	2042	4396	432	237	385	1154	5427	19383	1131903
2011		598	352	4907	2155	4671	474	245	412	1261	5569	20644	1265775
2012		684	508	5359	2401	5003	512	269	431	2680	5813	22399	1302615
2009	Улсын хэмжээнд	771	496	7140	2710	9017	3195	340	879	2358	11798	38704	2709652
2010		616	625	7497	3086	9179	3286	349	900	2114	11956	39608	2758269
2011		717	780	7943	3249	9420	3429	362	931	2345	11948	41124	2786322
2012		806	947	8597	3612	9916	3493	392	960	2593	12310	43626	2839711

ХАВСРАЛТ 2.

УЛААНБААТАР ХОТЫН 9 ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ, НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ БАЙРШИЛ, ХАНГАМЖ

Он	Дүүрэг	Удирдах ажилтан	Мэргэжилтэн	Их эмч	Эм зүйч, бусад дээд	Сувилагч	Эх баригч, бага эмч	гэрлийн техникч	Лаборант	Эм найруулагч, бусад	Бусад ажилтан	Нийт	Дундаж Хүн ам
2009	Баянгол	3	2	76	8	42	9	3	8	4	29	184	167219
2010		3	2	72	7	48	8	2	8	2	34	186	172065
2011		2	2	68	9	45	9	2	8	1	28	174	179978
2012		2	8	78	11	49	8	1	8	1	32	199	188607.5
2009	Баянзүрх	10	10	124	12	112	11	4	11	8	87	389	228379
2010		10	10	124	16	115	11	4	11	2	104	407	242717
2011		11	17	131	17	118	12	4	13	10	103	436	258119
2012		11	25	136	17	122	8	4	15	13	108	462	274643
2009	Сонгино-Хайрхан	6	3	122	13	119	27	6	15	25	102	438	226311
2010		6	1	121	23	118	21	5	14	2	133	444	236868
2011		6	2	124	18	134	22	5	14	3	126	454	246837
2012		7	11	139	23	133	19	5	15	5	142	499	254702
2009	Сүхбаатар	4	2	101	28	97	13	3	9	5	90	352	131297
2010		4	2	106	27	101	13	2	10	2	90	358	134106
2011		5	8	98	28	98	12	3	10	5	94	361	136010
2012		6	14	107	27	110	9	4	11	5	91	384	137375.5
2009	Чингэлтэй	1	4	88	15	95	8	3	10	5	82	311	138017
2010		1	3	86	13	95	13	3	11	2	76	311	140631
2011		1	8	84	21	92	8	2	11	5	79	311	144341
2012		1	12	97	21	106	10	3	12	5	88	355	150277.5
2009	Хан-Уул	10	1	91	9	91	8	4	13	6	63	296	96743
2010		8	3	88	11	93	6	3	12	3	69	296	101491
2011		5	1	93	21	94	9	3	12	6	77	321	108111
2012		5	8	102	19	103	4	3	13	3	74	335	115949
2009	Налайх	3	2	56	12	85	20	2	8	23	77	288	28634
2010		3	2	48	18	90	16	2	8	1	92	284	29665
2011		2	4	57	15	95	19	2	8	4	87	293	30837
2012		2	6	57	19	102	17	2	9	1	92	307	31985.5
2009	Багануур	4	1	53	3	86	19	2	8	8	89	273	25923
2010		4	1	54	2	87	20	1	8	5	93	276	25876
2011		3	2	56	2	90	20	2	8	9	91	287	26390
2012		2	7	69	8	94	24	2	8	1	73	299	29970
2009	Багахангай	1	-	5	1	7	-	-	-	1	13	28	3803
2010		-	-	4	2	5	-	-	-	-	12	23	3679
2011		-	-	5	3	5	-	-	-	-	12	25	3631
2012		1	-	4	3	7	-	-	-	-	12	27	3687
2009	Нийт	42	25	716	101	734	115	27	82	85	632	2559	1046326
2010		39	24	703	127	752	112	24	82	19	703	2585	1087098
2011		36	47	716	134	771	111	23	84	43	697	2662	1134254
2012		39	91	789	148	829	99	26	91	42	712	2867	1184197

ХАВСРАЛТ 3.

ЭМЯ-НЫ ХАРЬЯА ТӨВ ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВҮҮДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ БАЙРШИЛ ХАНГАМЖ

Байгууллага	Нийт ажиллах хүчний тоо	Үүнээс тоогоор		Хүйсийн харьцаа Хувиар		Эрдмийн болон боловсролын зэрэгтэй ажиллах хүчин		Сурган заах арга зүйн эрх авсан, мэргэшсэн	Мэргэжлийн зэрэгтэй ажиллах хүчин		Шинээр мэргэшүүлэх хэрэгцээ-тоогоор		Шаардлагатай хүний нөөцийн тоо	
		Их эмч	Сувилагч	Эр	Эм	ШУ-ны болон АУ-ны доктор	Магистр		Их эмч, бусад дээд	Сувилагч, тусгай	Их эмч	Бусад	Их эмч	Бусад
УНТЭ	730	162	286	15.3	84.7	9	48	26	68	136	28	3	106	323
УХТЭ	411	75	142	18.1	81.9	5	10	-	42	55	16	20	20	10
УГТЭ	655	142	237	16.1	83.9	13	74	1	103	87	72	46	53	-
ГССҮТ	512	96	183	20.2	79.8	6	7	40	36	12	42	31	7	13
ХСҮТ	423	91	128	21.3	78.7	15	35	9	65	79	32	24	19	144
ЭХЭМҮТ	1034	227	424	10.2	89.8	17	51	71	143	159	47	457	16	9
ХӨСҮТ	743	189	198	10.8	89.2	7	3	-	76	31	-	60	1	6
АӨСҮТ	143	36	31	14.7	85.3	4	13	4	17	6	10	-	22	86
СЭМҮТ	417	66	100	20.9	79.1	2	9	9	29	13	70	-	18	39
ГҮТ	23	5	2	43.5	56.5	2	1	-	3	-	-	-	5	-
ЭСҮТ	56	24	-	28.6	71.4	3	8	2	11	12	7	3	20	3
ЗӨСҮТ	104	27	-	27.9	72.1	6	13	3	14	3	10	30	-	6
ЦССҮТ	55	9	28	16.4	83.6	1	3	3	4	11	12	25	17	78
ХТС	109	13	39	5.5	94.5	-	6	-	2	16	-	-	-	6
Бүгд	5415	1162	1798	19.3	80.7	90	281	168	613	620	346	699	304	723

ХАВСРАЛТ 4.

ЭМЯ-НЫ ХАРЬЯА ТӨВ ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВҮҮДИЙН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХАРЬЦАА
БА ЭХНИЙ БАЙРАНД ОРЖ ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖИЛ

Байгууллага	Нийт ажиллах хүчний залуу болон ахмад ажиллах хүчний харьцаа-хувиар		Их эмчийн төрөлжсөн мэргэжлээр , эхний байранд орж байгаа мэргэжил, хувиар														
	20-39 насны залуучууд	50- ба түүнээс дээш насны ахмадууд	Дотор	Мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээ	Мэс засал	Дүрс оношилгоо	Арьс гоо засал	Мэдрэл	Эх барих эмгэгтэйчүүд	Хүүхэд	Гэмтэл, согог	леборатори	Хавдар судлаач	Халдвар, тархвар судлаач, сурьез	Сэтгэцийн эмгэг судлал	Эмгэг судлаач, шүүхийн шинжээч	Гоц халдварт
УНТЭ	48.2	15.8	22.8	15.4	9.2	10.4		-	-	-	-	-	-				
УХТЭ	43.8	22.4	32.0	8.0	12.0	9.3		5.3	-	-	-	-	-				
УГТЭ	52.8	13.6	26.0	13.4	21.1	9.2		6.3	-	-	-	-	-				
ГССҮТ	53.1	14.3	-	12.5	-	-		-	-	-	68.8	8.3	-				
ХСҮТ	48.5	15.8	-	8.8	31.8	16.5		-	-	-	-	12.1	23.1				
ЭХЭМҮТ	46.5	16.6		13.2	5.3				23.8	31.7		3.5					
ХӨСҮТ	47.9	17.4			3.2	4.2						15.4		59.3			
АӨСҮТ	39.1	20.3	-					77.7				8.3					
СЭМҮТ	52.9	31.2													90.9		
ГҮТ	56.5	21.7	20.0					20.0							20.0		
ЭСҮТ	44.6	30.3														100.	
ЗӨСҮТ	45.2	26.0												29.6			33.3
ЦССҮТ	61.8	9.1										33.3					
ХТС	36.7	24.7						7.7		46.2							